

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
2019 ОНЫ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

“НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

1.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийслэл хэрэгжүүлэхээр тусгасан 209 арга хэмжээнээс нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт хамаарах 3 ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тооцон ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана.

- ✓ Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх замаар хэрэгцээ шаардлагыг хангах зохицуулалт хийх, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах, шинээр хөрөнгө худалдан авах асуудлыг оновчтой шийдвэрлэж, зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх /Хэрэгжилт 100%/
- ✓ Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, төрийн байгууллагуудын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо, төрөл, нормативыг тогтоох, хяналт тавих замаар төсвийн зардлыг бууруулах арга хэмжээ авах /Хэрэгжилт 100%/
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн мэдээллийн системийг боловсронгуй болгох /Хэрэгжилт 100%/

Дээрх 3 арга хэмжээний хэрэгжилтийн явцын мэдээг НЗДТГ-т хагас жилийн байдлаар хүргүүлж, 2019.10.21-ний өдрийн 10/4969 тоот албан бичгээр хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжид “3 арга хэмжээнээс 1 арга хэмжээ 100 хувийн, 2 арга хэмжээ 70 хувийн нийт 80 хувийн хэрэгжилттэй” гэсний дагуу жилийн эцсийн байдлаар зорилтын хэрэгжилтийг хүргүүлэхэд хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, хүрсэн үр дүнгийн талаар танилцуулга, байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамт НЗДТГ-т 3 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан.

1.2 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 1 зорилтын хүрээнд Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар нь үндсэн чиг үүргийнхээ дагуу Эдийн засаг нийгмийг

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 2 ажлыг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллалаа.

1.2.1 Хөтөлбөрийн зорилт

Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг өгөөжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Нийслэлийн өмчид байгаа хөрөнгө, өмчит үйлдвэрийн газруудын үр ашгийг нэмэгдүүлж, шинэ механизмыг нэвтрүүлнэ.

Өмчит үйлдвэрийн газруудын үр ашгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2 төсөвт үйлдвэрийн газрыг нэгтгэн, шинээр 3 байгууллагын дүрмийг НИТХТ-ийн хурлаар батлуулан, 3 төсөвт үйлдвэрийн газрыг менежментийн гэрээгээр ажиллуулах этгээдийг сонгон шалгаруулах журам, гэрээний төслийг боловсруулж, НИТХТ-ийн 2019.03.22-ны өдрийн 45, 46, 47, 48 дугаар тогтоолуудаар батлуулсан.

Мөн нийслэлийн өмч хувьчлалын бодлогыг сайжруулах 2019 оны ажлын хүрээнд НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн өмчийг хувьчлах журам, Нийслэлийн өмч хувьчлах комиссын ажиллах журмын дагуу дуудлага худалдааг зохион байгуулан 2 барилга байгууламжийг худалдан борлуулж нийслэлийн төсөвт **314,9 сая** төгрөгийг төвлөрүүлсэн.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын бүтэц, зохион байгуулалтын талаар			
1	Нэгтгэх	“Минж нутагшуулах, үржүүлэх төслийн нэгж” ОНӨТҮГ	НИТХТ-ийн 2019.01.23-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Нийслэлийн Байгаль орчны газартай нэгтгэхээр шийдвэрлүүлсэн.
2		Ахмадын хотхон-1 ОНӨААТҮГ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 100 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019.07.10-ны өдрийн А/706 дугаар захирамжаар Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ийн харьяа нэгж болгон зохион байгуулахаар шийдвэрлүүлсэн.
3	Шинээр байгуулах	“Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент” ХК	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 179 дүгээр тогтоолоор байгуулж, дүрмийг батлуулсан.
4		“Улаанбаатар спорт менежмент” ХК	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 65 дугаар тогтоолоор байгуулж, дүрмийг батлуулсан.
5		“Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ашиглалтын өмнөх захиргаа” ОНӨТҮГ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019.11.12-ны өдрийн 182 дугаар тогтоолоор байгуулж, дүрмийг батлуулсан.
6	Менежментийн гэрээгээр ажиллуулах	“Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019.03.22-ны өдрийн 47 дугаар тогтоолоор
7	этгээдтэй байгуулах гэрээний төсөл	“Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын халуун ус бүхий үйлчилгээний төв	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019.03.22-ны өдрийн 48 дугаар тогтоолоор
8		Багахангай Мах боловсруулах үйлдвэр НӨҮГ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019.03.22-ны өдрийн 46 дугаар тогтоолоор

Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар:

Төсвийн зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт **7,149 сая** хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлсэн.

Мөн нийслэлийн өмчийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор ашиглалтын шаардлага хангахгүй, үлдэх өртөггүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй **4,433 сая** төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 18 барилга, байгууламж, **2,082.1 сая** төгрөгийн 159 тээврийн хэрэгсэл, 265 байгууллагын **10,197.4 сая** төгрөг төгрөгийн хөдлөх хөрөнгө, нийт **16,712.5 сая** төгрөгийн эд хөрөнгийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлүүлэн, үр ашиггүй нь тогтоогдсон хөрөнгийг үнэлж, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулж **160.4 сая** төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлж ажилласан.

1.2.2 Хөтөлбөрийн зорилт

Үл хөдлөх эд хөрөнгийн дахин үнэлгээний аргачлалын төслийг боловсруулж хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийг үнэлэх ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авна. /Хэрэгжилт 90%/

Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийх аргачлал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 367 дугаар тогтоолоор батлагдсан зааврын дагуу нийт 9 дүүргийн нийслэлийн 100 хувийн өмчтэй 520 төсөвт байгууллага хамрагдсан.

Дахин үнэлгээнд хамрагдсан нийслэлийн өмчит 520 байгууллагын газар эзэмших эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах аргачлалын дагуу 478 хуулийн этгээд, эзэмшиж буй 4,2038,918.69 мкв буюу 4,203.89 га талбайтай 1255 нэгж талбар газраа суурь үнэлгээгээр үнэлж, 893,743.2 сая төгрөгийн үнэлгээ бүхий газар эзэмших эрхээ санхүүгийн тайлангийн биет бус хөрөнгөнд тусгасан. Мөн нийслэлийн өмчийн барилга байгууламжийн 2018 оны бүртгэл, үнэлгээний нэгтгэлд 515 хуулийн этгээдийн 23,970 нэрийн 1,292,267.4 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий хөрөнгийг нэгтгэж 1,372,317.1 сая төгрөгөөр үнэлэгдсэн байна.

Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр 2018.12.31-ны өдрийн байдлаар нийслэлийн өмчит байгууллагын балансад бүртгэлтэй 11,290,346.5 мянган төгрөгийн 176 хөрөнгө дутагдсан, 3,330,323.7 мянган төгрөгийн 76 хөрөнгө маргаантай, устаж үгүй болсон, үлдэх өртөггүй, давхар бүртгэлтэй, буулган барилга баригдсан зэрэг зөрчилтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний ажлын явцад илэрсэн нийслэлийн өмчийн бүртгэлд тусгагдаагүй 24,945,6 сая төгрөгийн өртөгтэй 14 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэх тогтоолын төслийг боловсруулан, 2019.12.11-ний өдрийн 2008 дугаартай саналын хуудсаар санал авч байна.

1.2.3 Хөтөлбөрийн зорилт

"Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний загвар" төсөл хэрэгжүүлж, "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, эрүүл, баталгаат хоол хүнс хэрэглэх нөхцөл бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавина. /Хэрэгжилт 100%/

2019-2020 оны хичээлийн жилд "Үдийн цай" хөтөлбөр хэрэгжүүлэгч болон цайны газрын үйл ажиллагаа явуулах нийт 113 аж ахуй нэгжийн түрээсийн гэрээг батлуулсан. Үүнээс 2019 онд давхардсан тоогоор 40 сургуулийн сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт орж ажилласан. Сонгон шалгаруулалттай холбоотой аж ахуйн нэгжээс ирүүлсэн 10 өргөдөл, гомдлыг хүлээн авч танилцан зохих журмын дагуу шийдвэрлэсэн.

"Үдийн цай" хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжээс 2019-2020 /хичээлийн жилийн/ оны төсөвт 514,298,946 төгрөг төвлөрүүлэхээр баталснаас 2019 оны 12 дугаар сарын 30 ний өдрийн байдлаар **264,870,550 төгрөг** төвлөрүүлсэн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ " ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН"

Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 73 ажлыг тусган, үе шаттай зохион байгуулан хэрэгжилтийг ханган биелэлтэд хяналт тавин ажилласан байна.

1. Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө
2. Байгууллагын үйл ажиллагаанд байнга мөрдөж ажиллах заавар, журам, стандартыг хэрэгжүүлэх, 2019 оны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр шалган зааварлах ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөө
3. "Иргэдийн оролцоотой - Хөгжлийн жил"-ийн хүрээнд 2019 онд хийх ажлын төлөвлөгөө
4. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2019 оны төлөвлөгөө
5. "Мэдээллийн цаг" сургалтын төлөвлөгөө
6. Шинээр санаачлан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө
7. Архивын ажлын төлөвлөгөө
8. Засгийн газрын 2017 оны 01 албан даалгавар, Засгийн газрын 2018 оны 32, 258 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө
9. Авлигын эсрэг төлөвлөгөө
10. Байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө
11. "Эрүүл ажлын байр" удирдамжийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

2.1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

2.1.1 Тогтоол, шийдвэр, захирамжийн биелэлтийг 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийг өссөн дүнгээр харуулбал:

Жилийн эцсийн байдлаар:

		Нийт	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэмдэглэл	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлын тэмдэглэл	НЗД-ын зөвлөлийн хурлын тэмдэглэл	НЗД-ын захирамж /Үндсэн үйл ажиллагааны/	НЗД-ын захирамж /Эрх шилжсэн/	НЗД-ын захирамж /захиалагчийн хяналт/
Хяналтад авсан нийт шийдвэрлэлтийн тоо		342	2	4	3	42	1	3	2	89	170	27
Хяналтад авсан нийт заалтын тоо		378	12	23	3	46	1	3	4	89	170	27
Бүрэн хэрэгжсэн	100%	182	12	21	3	34	1	3	3	84	2	20
Хэрэгжиж байгаа	70%	5	-	1	-	-	-	-	-	3	-	-
Эрчимжүүлэх шаардлагатай	30%	1	-	-	-	1	-	-	-	-	-	-
Хэрэгжээгүй	0%	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Үүн ээс	Зохион байгуулалтаас шалтгаалсан	0	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хөрөнгө дутагдса наас шалтгаалсан	0	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй /үнэлэх боломжгүй/		191	-	1	-	12	-	-	1	2	168	7
Гүйцэтгэлийн хувь		98,7%	100%	95,6%	100%	97,9%	100%	100%	100%	99,7%	98,6%	98,5%
Үнэлгээний хувь		98,7%	100%	95,6%	100%	97,9%	100%	100%	100%	99,7%	98,6%	98,5%

2.2 Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн болон байгууллагын шуурхай зөвлөгөөний талаар

	Хурлын тоо	Үүрэг даагавар	Биелэлт	Тайлбар
Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн	21 удаа	109	93%	- Он дамжин шийдвэрлэгдэх төсөл, арга хэмжээ
Байгууллагын шуурхай зөвлөгөөн	23 удаа	189	87,2%	- Бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх ажил

2.3 Цаг үеийн шинж чанартай төлөвлөгөө, тайлангийн талаар

Тайлан	Тайлагнасан байдал	Үүрэг даалгавар	Биелэлт
--------	--------------------	-----------------	---------

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Сарын онцлох ажлын тайлан	9 удаа	-	100%
ЗГ-ыг 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах борлуулалтын цэгүүдэд хяналт тавьсан ажлын тайлан	20 удаа	1 үүрэг даалгавар	100%
Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	Улирал тутам 3 удаа	1 арга хэмжээ	100%
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах төлөвлөгөөний тайлан	Улирал тутам 3 удаа	2 арга хэмжээ	100%
Худалдан авах ажиллагааны тайлан	6 удаа	1 арга хэмжээ	100%

Мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсний эхний 100 хоногт хийж хэрэгжүүлсэн томоохон 5 ажлын тайланг гарган НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 2019.06.05-ны өдрийн 1/676 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлыг 4 удаа, Ёс зүйн хороог 4 удаа хуралдуулан, хурлын тэмдэглэлийг хөтөлж, баталгаажуулан, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Тайлант хугацаанд газрын даргын шуурхай хурал 23 удаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор нийт 189 үүрэг даалгавар өгөгдөж, үүрэг даалгаврын хэрэгжилт 87,2%-ийн биелэлттэй байна.

2.2 Зорилт жилийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын талаар:

НЗД-ын 2019 оны 01 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил болгон зарлах тухай” захирамжийн дагуу байгууллага дээр 4 зорилтын хүрээнд 16 хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж хагас, бүтэн жилээр хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

- Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах
- Төрийн байгууллагын чадавхийг сайжруулах
- Төрийн албан хаагчийн сахилга харцуцлагыг дээшлүүлэх
- Нийслэл Улаанбаатар хотын бүтээн байгуулалт, дэд бүтэц, байгаль орчин, тохижилт, ногоон байгууламж, нийгмийн салбарын хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

ГУРАВДУГААР БҮЛЭГ

“БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН” ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ:










Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтэц, тэдгээрийн орон тооны хязгаарыг батлах тухай” 100 дугаар тогтоолоор байгууллагын нэр, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/241 дүгээр захирамжаар бүтэц, орон тооны хязгаар, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/283 дугаар захирамжаар тус байгууллагын дүрэм тус тус шинэчлэн батлагдсаныг үндэслэн газрын даргын 2019.04.25-ны өдрийн Б/23 дугаар тушаалаар байгууллагын

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

бүтэц, орон тооны, 2019.09.20-ны өдрийн А/326 дугаар тушаалаар зохион байгуулалт, чиг үүргийн өөрчлөлтүүдийг боловсруулан баталсан.

Газрын дарга-1, Орлогч дарга-2, Нэгжийн дарга-4, ахлах мэргэжилтэн-5, төрийн захиргааны албан тушаалын ангилалд – 37 /*лүүнээс: албан хаагч түр орлон гүйцэтгэгч-3, сул орон тоо-2*/, төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд-27 /*лүүнээс: сул орон тоо-1*/, гэрээт ажилтан-2 гэсэн бүрэлдэхүүнтэй ажилласан.

Байгууллагын нэр, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан дотоод үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж буй дараах 6 журам, 3 дүрмийг шинэчлэн батлав.

 <p>2019.06.19-ний А/170 дугаар тушаалаар "Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын хөдөлмөрийн дотоод журам"</p>	 <p>2019.08.05-ны А/286 дугаар тушаалаар "Удирдлагын зөвлөлийн ажиллах журам"</p>	 <p>2019.07.18-ны А/261 дүгээр тушаалаар "Газрын шуурхай зөвлөгөөний журам"</p>
 <p>2019.08.22-ны А/304 дүгээр тушаалаар "Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам"</p>	 <p>2019.06.28-ны А/204 дүгээр тушаалаар "Байгууллагын архивын ажлын дүрэм"</p>	 <p>2019.08.13-ны А/300 дугаар тушаалаар "Байгууллагын галын аюулгүйн дүрэм"</p>
 <p>2019.07.24-ны А/266 дугаар тушаалаар "Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрэм"</p>	 <p>2019.06.19-ний А/169 дүгээр тушаалаар "Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам"</p>	 <p>2019.08.13-ны А/299 дүгээр тушаалаар "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам"</p>

3.1. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулах талаар

3.1.1 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын захиралтай контракт гэрээ байгуулах, гэрээний биелэлт дүгнэх, зорилтот түвшинг тогтоох 2018 оны зорилт түвшин

НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай Контракт байгуулах, дүгнэх журам"-ын дагуу Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/185 дугаар захирамжаар "Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын захиралтай байгуулсан 2018 оны контрактыг дүгнэх, 2019 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын төсөл бэлтгэх үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийг байгуулсан. Тус ажлын хүрээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой 17 үйлдвэрийн газруудын 2018 оны зорилтот түвшингийн биелэлтийг гаргасан боловч Ажлын хэсэг Контрактын дүнг хэлэлцээгүй болно.

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын 2018 оны санхүүгийн үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын орлого, зардал, ашиг алдагдал:

/мян.төг/

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

№	Үзүүлэлт	2018 оны зорилт	2018 оны гүйцэтгэл	2018 оны зөрүү	Биелэлт хувиар	2019 оны зорилт	2018 оны гүйцэтгэлээс
1	Нийт орлого	223,988,172.7	243,807,476.00	20,407,286.8	109.5	263,038,888.6	18,643,429.0
2	Нийт зардал	253,813,124.8	275,026,857.30	21,678,447.4	108.4	308,948,636.2	33,457,064.0
3	Ашиг алдагдал	-29,824,952.0	-31,219,381.30	-1,271,160.5	104.2	-45,909,747.6	-14,813,635.0
4	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	1.13	1.13	1.06	1	1.17	0.05

2018 онд нийт 17 үйлдвэрийн газрын захиралтай Контракт байгуулсны дагуу тус үйлдвэрийн газрууд нь нийт 243,8 тэрбум төгрөгийн орлого олж, 275,0 тэрбум төгрөгийн зардал гарган 31,2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь зорилтот түвшингээс орлого 9,5 хувиар, зардал 8,4 хувиар давж, улмаар алдагдал зорилтот түвшнээс 4,2 хувиар буюу 1,2 тэрбум төгрөгөөр өсжээ. Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлын хэмжээ 1,13 буюу зорилтот түвшингийн хэмжээнд гарсан байна. Задалж харуулбал:

№	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэрс	Нийт орлого		Нийт зардал		Ашиг алдагдал	
		2018 оны зорилт	2018 оны гүйцэтгэл	2018 оны зорилт	2018 оны гүйцэтгэл	2018 оны зорилт	2018 оны гүйцэтгэл
1	Орон сууц нийтийн аж ахуй удирдах газар	79 049 009.6	83 092 166.4	83 603 422.9	90 330 427.4	(4 554 413.3)	(7 238 261.0)
2	Ус сувгийн удирдах газар	49 534 897.0	58 000 328.2	67 566 313.0	75 077 647.8	(18 031 416.0)	(17 077 319.6)
3	Зорчигч тээврийн нэгтгэл	39 369 550.2	39 258 813.1	44 366 880.1	43 870 786.9	(4 997 329.9)	(4 611 973.8)
4	Зорчигч тээвэр гурав	3 527 286.6	3 820 129.6	4 926 880.1	4 306 537.1	(1 399 593.5)	(486 407.5)
5	Хот тохижилтын газар	12 199 821.0	14 369 375.7	11 813 740.0	13 888 428.6	386 081.0	480 947.1
6	УБ зам засвар, арчлалтын газар	9 481 227.0	15 350 616.0	9 406 448.9	15 330 421.0	74 778.1	20 195.0
7	Өсвөр үе хүнс	5 943 000.7	6 078 821.7	5 852 917.1	6 003 699.9	90 083.6	75 121.8
8	Хүнс хангамж төв	4 657 980.0	4 848 303.6	4 596 186.6	4 853 094.9	61 793.4	(4 791.3)
9	Багачууд хүнс	4 096 899.8	3 756 551.8	4 038 706.1	3 748 751.1	58 193.7	7 800.7
10	Асгат	3 372 947.0	3 910 288.5	3 341 062.4	3 877 898.9	31 884.6	32 389.6
11	Геодези, усны барилга байгууламжийн газар	3 624 545.5	3 491 521.4	5 231 747.0	5 261 351.0	(1 607 201.5)	(1 769 829.6)
12	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар	2 877 138.8	2 660 803.5	3 384 957.1	3 472 632.2	(507 818.3)	(811 828.7)
13	Хөрөнгө оруулалтын газар	2 637 320.0	2 255 989.0	2 388 118.0	2 245 696.0	249 202.0	10 293.0
14	Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн	2 128 000.0	1 590 585.5	1 915 451.0	1 562 924.4	212 549.0	27 661.1
15	Гэрлэх ёслолын ордон	969 940.0	1 242 264.6	866 820.2	1 006 463.4	103 119.8	235 801.2

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

16	Үртсэн шахмал түлшний үйлдвэр	25 830.0	25 001.5	140 920.0	137 358.4	(115 090.0)	(112 356.9)
17	Багахангайн Мах боловсруулах үйлдвэр	58 257.5	55 915.9	58 257.5	52 738.3	-	3 177.6
Нийт дүн		223 553 650.7	243 807 476.0	253 498 828.0	275 026 857.3	(29 945 177.3)	(31 219 381.3)

2019 оны зорилт түвшин

Үйлдвэрийн газруудаас ирүүлсэн 2019 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын төслийг хянан, Нийслэлийн Засаг даргын 2019.08.05-ны өдрийн А/793 дугаар захирамжаар орлогыг 263,2 тэрбум төгрөг, зардлыг 309.1 тэрбум төгрөг, алдагдалыг 45,9 тэрбум төгрөг, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлыг 1,17 төгрөгөөр батлуулаад байна. Мөн хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөг батлуулав.

/мян.төг/

№	Үзүүлэлт	2019 он		
		Зорилт	2018 оны гүйцэтгэлээс	Гүйцэтгэл /эхний хагас жилийн байдлаар/
1	Нийт орлого	263,218,272.53	19,410,796.53	133,864,299.40
2	Нийт зардал	309,137,777.65	34,110,920.35	151,525,054.10
3	Нийт ашиг/алдагдал	-45,919,505.12	14,700,123.82	(17,660,754.70)
	Борлуулалтын1 төг. ногдох зардал	1.17	0.04	1,13

Аж ахуй нэгж бүрээр задалж харуулвал:

/мян.төг/

№	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэрс	Нийт орлого		Нийт зардал		Ашиг алдагдал		Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал
		2018 оны гүйцэтгэл	2019 оны зорилт	2018 оны гүйцэтгэл	2019 оны зорилт	2018 оны гүйцэтгэл	2019 оны зорилт	
1	Орон сууц нийтийн аж ахуй удирдах газар	83 092 166.4	89 747 393.2	90 330 427.4	100 814 014.2	(7 238 261.0)	(11 066 621.0)	1.12
2	Ус сувгийн удирдах газар	58 000 328.2	65 180 105.9	75 077 647.8	85 148 889.0	(17 077 319.6)	(19 968 783.1)	1.31
3	Зорчигч тээврийн нэгтгэл	39 258 813.1	38 819 160.0	43 870 786.9	42 821 030.9	(4 611 973.8)	(4 001 870.9)	1.10
4	Зорчигч тээвэр гурав	3 820 129.6	11 611 324.6	4 306 537.1	15 293 619.60	(486 407.5)	(3 682 295.0)	1.32
5	Хот тохижилтын газар	14 369 375.7	13 584 164.2	13 888 428.6	15 910 596.1	480 947.1	(2 326 431.9)	1.17
6	УБ зам засвар, арчлалтын газар	15 350 616.0	12 245 500.0	15 330 421.0	12 145 288.0	20 195.0	100 212.0	0.99
7	Өсвөр үе хүнс	6 078 821.7	6 255 831.3	6 003 699.9	6 180 176.6	75 121.8	75 654.7	0.99
8	Хүнс хангамж төв	4 848 303.6	4 941 965.0	4 853 094.9	4 892 583.5	(4 791.3)	49 381.5	0.99
9	Багачууд хүнс	3 756 551.8	4 049 047.4	3 748 751.1	4 027 222.7	7 800.7	21 824.7	0.99
10	Асгат	3 910 288.5	3 424 967.2	3 877 898.9	3 390 400.7	32 389.6	34 566.5	0.99
11	Геодези, усны барилга байгууламжийн газар	3 491 521.4	3 610 397.8	5 261 351.0	8 085 187.4	(1 769 829.6)	(4 474 789.5)	2.24

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

12	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар	2 660 803.5	4 040 314.0	3 472 632.2	4 897 704.0	(811 828.7)	(857 390.0)	1.21
13	Хөрөнгө оруулалтын газар	2 255 989.0	2 800 668.0	2 245 696.0	2 735 107.0	10 293.0	65 561.0	0.98
14	Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн	1 590 585.5	1 585 000.0	1 562 924.4	1 548 770.2	27 661.1	36 229.8	0.98
15	Гэрлэх ёслолын ордон	1 242 264.6	1 143 050.0	1 006 463.4	1 067 803.9	235 801.2	75 246.1	0.93
16	Үртсэн шахмал түлшний үйлдвэр	25 001.5	120 093.6	137 358.4	120 093.6	(112 356.9)	-	1.00
17	Багахангайн Мах боловсруулах үйлдвэр	55 915.9	59 290.3	52 738.3	59 290.3	3 177.6	-	1.00
	Нийт дүн	243 807 476.0	263 218 272.5	275 026 857.3	309 137 777.7	(31 219 381.3)	(45 919 505.1)	1.17

Алдагдал өсч, ашиг буурахад нөлөөлсөн дараах хүчин зүйлс

- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших ашиглах эрх болон үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлгээ хийгдсэнтэй холбоотойгоор үл хөдлөх хөрөнгийн элэгдлийн зардал өссөн;
- Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2018 оны 05 дугаар тогтоол гарсантай холбогдуулан цалингийн зардал өссөн;
- Холбогдох зохицуулах хороодын үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг Ус сувгийн удирдах газар 17,0 тэрбум, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 7,2 тэрбум, Зорчигч тээврийн нэгтгэл 4,6 тэрбум төгрөг, Нийтийн эзэмшлийн хөрөнгө бүртгэлтэй байдгаас элэгдлийн зардлаар Геодези, усны барилга байгууламжийн газар 1,7 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтад “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгана.” гэж заасны дагуу нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай Контракт гэрээ байгуулан ажилладаг.

Зорилтот түвшин батлагдсантай холбоотойгоор 17 үйлдвэрийн газрын захиралтай 2019 онд Контракт гэрээ байгуулсан.



2019 оны байдлаар 17 аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд нь 133,9 тэрбум төгрөгийн орлого олж, 151,5 тэрбум төгрөгийн зардал гарган, 17,7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардал 1,13 болсон байна.

Мөн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дээд хязгаарыг 21,3 тэрбум байхаар хянаж өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр шинээр хийгдэх хөрөнгө оруулалт, шинэчлэлтийн ажил худалдан авах хөрөнгө, бараа материалыг нэр төрлөөр нь багцлан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолыг баримтлан хөрөнгө худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллахыг зөвлөн ажиллалаа.

Худалдан авах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж буй байдалд хяналт тавин ажиллаж, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаас бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар зохион байгуулсан 112 үнэлгээний хороонд холбогдох албан тушаалтнууд орж ажилласан.

3.1.2 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын бүтэц, зохион байгуулалт, дүрэмд өөрчлөлт оруулах талаар:

1. Нийслэлийн төсвийн ачааллыг бууруулах зорилгоор “Минж нутагшуулах, үржүүлэх төслийн нэгж” ОНӨТҮГ-ыг татан буулгаж, Нийслэлийн Байгаль орчны газартай нэгтгэх асуудлыг судлаж, НИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлэн, НИТХТ-ийн 2019.01.23-ны өдрийн 17 дугаар тогтоолоор шийдвэрлүүлж, татан буулгах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа. Тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын 2019.02.26-ны өдрийн А/168 дугаар захирамжаар татан буулгах, нэгтгэх ажлыг зохион байгуулах комисс томилогдон доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- *Журмын дагуу татан буугдаж байгаа тул өр авлагатай иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд тооцоо нийлэх талаар Өдрийн сонинд 2019.03.06-ны өдөр зар мэдээг байршуулсан.*
- *Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст тус газарт татварын хяналт оруулж, дүгнэлт гаргаж өгөх талаар 2019.03.06-ны өдрийн 2/267 тоот албан бичгийг хүргүүлээд байна.*
- *Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр 2019.04.03-ны өдөр тус газарт ажиллаж хөрөнгийг тоо хэмжээ үнэ өртгөөр нь тулгаж хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулсан.*

2. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 100 дугаар тогтоолоор түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх, нийгмийн зорилтод бүлгийг орон сууцжуулах зорилгоор Ахмадын хотхон-1 ОНӨААТҮГ-ыг Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ийн харьяа нэгж болгон зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг даргын 2019.07.10-ны өдрийн А/706 дугаар захирамжаар “Ахмадын хотхон-1” ОНӨААТҮГ-ыг татан буулгах, нэгтгэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулагдан доорх ажлыг хийж гүйцэтгэлээ.

- *Ажлын хэсэг 2019.07.16-ны өдөр “Ахмадын хотхон-1” ОНӨААТҮГ-ын байранд очиж хөрөнгө хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж, актаар баталгаажуулж, 2014-2019 оны санхүүгийн тайланг 2019.06.30-ны өдрөөр тасалбар болгон Нийслэлийн Татварын газрын хяналт шалгалтыг оруулан, холбогдох дүгнэлтийг гаргуулсан.*

- “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК шилжин ирж буй 22 албан хаагчдыг хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн авч, ТУЗ-ын хурлаар бүтэц орон тоог шинэчилсэн.
- Хөрөнгө хүлээлцэх ажлын хэсгийн актын дагуу Ахмадын хотхон-1 ОНӨААТҮГ-аас балансаас балансад шилжин ирсэн нийт 14,731,467,352.02 төгрөгийн хөрөнгийг бүртгэн авах асуудлыг газрын даргын 2019 оны А/414 дүгээр тушаалаал шийдвэрлүүлсэн бөгөөд татан буулгаж байгаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай холбогдох өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, байгууллагын хаалтын балансыг 2019 оны эхний хагас жилийн байдлаар гарган Нийслэлийн Төрийн сангаар баталгаажуулаад байна.
- Татан буугдаж байгаа газрын бичиг баримтыг архивлан акт үйлдэн Нийслэлийн Архивын газарт хүлээлгэн өгсөн.

3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 179 дүгээр тогтоолоор “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулж, компаний дүрмийг баталсан.

- “Нийслэлийн 2019 оны төсөвт зохицуулалт, нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 23/15 дугаар тогтоолоор “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент” ХХК-ийн дүрмийн санд нийлүүлэх 5,0 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд зориулсан 300,0 сая төгрөгийг шилжүүлэх тухай НЗД-ын 2019 оны А/605 дугаар захирамж гаргуулан, Гүйцэтгэх захиралтай нийслэлийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих гэрээг байгуулан ажиллаж байна.

4. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 65 дугаар тогтоолоор “Улаанбаатар спорт менежмент” хувьцаат компанийг байгуулж, компаний дүрмийг баталсан. Нийслэлийн 2019 оны төсвийн 3.2.73-д тусгасан “Улаанбаатар спорт менежмент” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө болох 5,0 тэрбум төгрөгийг шилжүүлэх тухай Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/493 дугаар захирамж гаргуулан, “Улаанбаатар спорт менежмент” ХК-тай компанийн дүрмийн санд хуваарилсан нийслэлийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих тухай 2019.05.22-ны өдрийн 493-01 тоот гэрээг байгуулж, НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн баталсан хуваарийн дагуу санхүүжилтийг шилжүүлүүлэв.

5. Нийслэлийн Хан-уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй нийслэлийн төр захиргааны цогцолбор барилга баригдаж байгаатай холбогдуулан барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, байнгын ашиглалтад зүгшрүүлэх, инженерийн шугам сүлжээний туршилт тохируулгын ажилд хамтран ажиллах чиг үүрэг бүхий “Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ашиглалтын өмнөх захиргаа” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг байгуулах, дүрмийг батлуулах ажлыг зохион байгуулан, НИТХТ-ийн 2019.11.12-ны өдрийн 182 дугаар тогтоолоор шийдвэрлүүлээ.

3.1.3 НӨҮГ болон нийслэлийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ, УЗ-д нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх

Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой 21 хуулийн этгээдийн Удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах ажлыг зохион байгуулан дараах газруудын хуралд холбогдох мэргэжилтэнгүүдийг

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

оролцуулж, нийслэлийн өмчийн бодлого, менежментийн талаар саналыг тусгуулж ажиллалаа. Үүнд:

- Ус сувгийн удирдах газар-1
- Улаанбаатар зам засвар арчлалтын газар-1
- Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар-1
- Зорчигч тээвэр гурав-1
- Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газар-1



- Хот тохижилтын газар-1
- Зураг төслийн хүрээлэн-1
- Геодези усны барилга байгууламж-1 удаа тус тус хуралдсан байна.

Компанийн засаглалыг сайжруулах ажлын хүрээнд Санхүү эдийн засгийн их сургуультай хамтран Компаний засаглалын сургалтыг зохион байгуулан явуулж, нийслэлийн 100 хувийн өмчтэй хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон байгууллагын төлөөлөл хариуцсан нийт 12 албан хаагчдыг сургалтад хамрууллаа.

3.1.4. Ногдол ашгийн талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 130 дугаар тогтоолоор нийслэлийн өмчит үйлдвэрийн газрууд болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас 2018 онд нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг тогтоосны дагуу ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин ажилласан.

Дутуу ногдол ашгийг 2019 онд нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн байгууллагууд:

- *Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-аас **226,3 сая***
- *Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас **237 сая***
- *Улаанбаатар зам засвар арчлалт ОНӨААТҮГ-аас **20 сая***

НИТХТ-ийн 2019.10.08-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчит үйлдвэрийн газар болон нийслэлийн өмчийн оролцоотой компанийн 2018 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас 2019 онд нийслэлийн төсөвт **500,1 сая** төгрөг төвлөрүүлэхээс **459,6 сая** төгрөг төвлөрүүлсэн **92%**-ийн биелэлттэй бөгөөд Улаанбаатар зам засвар арчлалт ОНӨААТҮГ төвлөрүүлээгүй, Хишиг-Уул ХХК дутуу төвлөрүүлээд байна.

Нийт 2019 оны ногдол ашгийн төлөвлөгөө **650 сая** төгрөгөөс **944 сая** төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт **145,2%**-тай байна.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

2019 оны ногдол ашиг төвлөрүүлэлтийн мэдээ								
№	Байгууллагын нэрс	Нийслэлийн өмчийн оролцооны хувь	Ногдол ашиг тооцоох хувь	Төвлөрүүлэх НА-ийн дүн /Төсөлөөр/	НА-ийн төвлөрүүлсэн байдал	Дутуу	Хувь	
1	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ	100%	50%	240 473.5	216 426.2	24 047.4	90	
2	Улаанбаатар зам завсар арчлалт ОНӨААТҮГ	100%	50%	10 097.3		10 097.3	0	
3	"Өсвөр үе хүнс" ОНӨААТҮГ	100%	50%	37 560.9	33 804.8	3 756.1	90	
4	"Багачууд хүнс" ОНӨААТҮГ	100%	50%	3 900.3	3 900.3	0.0	100	
5	Асгат ОНӨААТҮГ	100%	50%	16 194.8	16 194.8	0.0	100	
6	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар	100%	50%	5 146.7	5 146.7	0.0	100	
7	Зураг төслийн хүрээлэн ОНӨААТҮГ	100%	50%	13 830.6	12,497.5	1,333.1	90	
8	Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ	100%	50%	117 900.5	117 900.5	0.0	100	
9	Хишиг Уул ХХК 34%			2 387.5	1,060.0	1,327.5	44	
10	Монголын хөлөг онгоцны бүртгэл хамтарсан компани ХХК	5%		52 686.0	52 686.0	0.0	100	
Дүн				500 178.3	459,616.9	40,561.4	92	
Урьд оны авалага								
1	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар			477 028.9	237,028.9	240,000.0		
2	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ			226 250.4	226 250.4	0.0		
3	Улаанбаатар зам завсар арчлалт ОНӨААТҮГ			78 327.8	20 000.0	58 327.8		
Авлагын дүн				781 607.1	483,279.3	240 000.0		
Нийт төсөвт төвлөрүүлсэн				1 281 785.4	942,896.2	280,561.4		

3.2. Хөрөнгийн хөдөлгөөний талаар хийж хэрэгжүүлсэн ажил

3.2.1. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн ажлын талаар:

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, буцалтгүй тусламж, гадаад дотоодын хандив бэлэглэлээр нийслэлийн өмчид шинээр бий болсон эд хөрөнгийг эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгах, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн дансны залруулга хийх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг акталж, данснаас хасах асуудлыг шийдвэрлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд нийслэл хотод улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын болон дотоодын хандив, буцалтгүй тусламж, зээлийн хөрөнгөөр **нийт 86,388.4 сая төгрөгийн** хөрөнгийг нийслэлийн өмчийн бүртгэлд тусгасан. Үүнд:

1. Барилга байгууламж 17 53,149.8 сая төгрөг
2. Тээврийн хэрэгсэл 112ш 10,412.5 сая төгрөг
3. ЭБХХК-ын хурлаар бүртгэсэн эд хөрөнгө: 5,245.6 сая төгрөг
4. Шинээр бий болсон эд хөрөнгө: 17,580.5 сая төгрөг

Нэг. Барилга байгууламж - 17 нэрийн 53 149.8 сая төгрөг

НИТХТ-ийн тогтоолоор бүртгэсэн барилга байгууламж – 17 нэрийн 53 149.8 сая төгрөг

- НИТХТ-ийн 2019.02.01-ний өдрийн 22 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2019.02.25-ны өдрийн А/124 тоот захирамжаар нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар баригдсан 355,528,938 төгрөгийн өртөг бүхий 8 ус түгээх байрыг
- НИТХТ-ийн 2019.02.01-ний өдрийн 23 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2019.02.25-ны өдрийн А/123 тоот захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 3,497,390,000 төгрөгийн өртөгтэй “Түрээсийн 70 айлын орон сууц”
- НИТХТ-ийн 2019.04.10-ны өдрийн 59 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2019.05.01-ны өдрийн А/400-р захирамжаар улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, концессын гэрээгээр Сонгинохайрхан дүүргийн 6, 12, 13, 21, 22 дугаар хороонд шинээр баригдаж ашиглалтад орсон нийт 6,935,547,908 төгрөгийн өртөг 5 барилга байгууламжийг,
- НИТХТ-ийн 2019.05.07-ны өдрийн 66 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2019.05.29-ний өдрийн А/506 тоот захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 1,341,315,262 төгрөгийн өртөг бүхий “40 айлын орон сууц”
- НИТХТ-ийн 2019.05.07-ны өдрийн 67 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2019.08.01-ний өдрийн А/781 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 516,113,292 төгрөгийн өртөгтэй Баянзүрх дүүргийн 27 дугаар хорооны цогцолборын барилгыг,
- НИТХТ-ийн 2019.06.11-ний өдрийн 97 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2019.08.01-ний А/777 тоот захирамжаар нийслэлийн төсвийн санхүүжилтээр ашиглалтад орсон 344,666,159 төгрөгийн өртөгтэй бага оврын цэвэрлэх байгууламжийг,
- НИТХТ-ийн 2019.06.11-ний 98 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2019.08.22-ны А/858 тоот захирамжаар Багануур дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар баригдсан 69,815,361 төгрөгийн өртөгтэй 2 ширхэг зөөврийн усан сан
- НИТХТ-ийн 2019.07.04-ны өдрийн 117 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2019.08.19-ны А/832 дугаар захирамжаар Сонгинохайрхан дүүргийн 15, 17, 18, 22 дугаар хороонд нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр болон концесс олгох гэрээ, хандиваар шинээр баригдаж ашиглалтад орсон нийт 3,309,113,634 төгрөгийн өртөг бүхий 4 барилга байгууламжийг,
- НИТХТ-ийн 2019.08.29-ны өдрийн 136, 137 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2019.10.23-ны өдрийн А/1108, А/1109 дүгээр захирамжаар концессын гэрээгээр баригдсан 1,645,566,576 сая төгрөгийн өртөгтэй Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 144 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл, 2,090,581,985 төгрөгийн өртөгтэй Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 83 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг,

- НИТХТ-ийн 143 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын А/1135 тоот захирамжаар 239,855,000 төгрөгийн өртөг бүхий байгууламж
- НИТХТ-ийн 2019.11.12-ны өдрийн 183 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2019.12.05-ны А/1288 тоот захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон 4,094,220,724 төгрөгийн өртөгтэй сургууль цэцэрлэгийн 3 барилга байгууламж
- НИТХТ-ийн 2019.11.25-ны өдрийн 192 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын А/1309 тоот захирамжаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны балансас шилжин ирсэн 175,000,000 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үйлдвэрлэл, технологийн паркийн барилга байгууламжийг, нийслэлийн өмчид бүртгэн, албан бичгээр тогтоол, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг эзэмшигч байгууллагуудад даалгасан.
- Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон нийт 34,558,7 сая төгрөгийн өртөгтэй “Буянт-Ухаа” хорооллын 20000м3/хон бохир ус цэвэрлэх байгууламж, дулаан хангамжийн эх үүсвэрийг нийслэлийн өмчид бүртгэн авах тогтоолын төслийг Нийслэлийн Засаг даргын 2019.12.05-ны өдрийн 02-01/6041 дүгээр албан бичгээр өргөн мэдүүлээд байна.
- Мөн төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний ажлын явцад илэрсэн нийслэлийн өмчийн бүртгэлд тусгагдаагүй байсан 24,945,6 сая төгрөгийн өртөгтэй 14 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэх тогтоолын төслийг боловсруулан, 2019.12.11-ний өдрийн 2008 дугаартай саналын хуудсаар санал авч байна.

НЗД-ын захирамжаар бүртгэсэн тээврийн хэрэгсэл – 10 412.5 сая төгрөг /112ш/

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/401 дүгээр захирамжаар 89,7 сая төгрөгийн 2, А/402 дугаар захирамжаар 777,0 сая төгрөгийн 6, А/484 дүгээр захирамжаар 39,4 сая төгрөгийн 2, А/782 дугаар захирамжаар 158,6 сая төгрөгийн 2, А/833 дугаар захирамжаар 302,3 сая төгрөгийн 4, А/1030 дугаар захирамжаар 163,6 сая төгрөгийн 3, А/1104 дүгээр захирамжаар 500,2 сая төгрөгийн 5, А/1106 дугаар захирамжаар 5 004,6 сая төгрөгийн 36, А/1107 дугаар захирамжаар 271,9 сая төгрөгийн 4, А/1159 дүгээр захирамжаар 314,9 сая төгрөгийн 3, А/1208 дугаар захирамжаар 109,1 сая төгрөгийн 3, А/1255 дугаар захирамжаар 170,2 сая төгрөгийн 5, А/1308 дугаар захирамжаар 188,3 сая төгрөгийн 4, А/1310 дугаар захирамжаар 1566,4 сая төгрөгийн 5, А/1314 дүгээр захирамжаар 155,0 сая төгрөгийн 8, А/1379 дүгээр захирамжаар 463,1 сая төгрөгийн 8, А/1380 дугаар захирамжаар 138,0 сая төгрөгийн 12, нийт 10 412,5 сая төгрөгийн үнэтэй 112 тээврийн хэрэгслийг бүртгэлд тусгасан.

ЭБХХХК-ын хурлын шийдвэрээр бүртгэсэн эд хөрөнгө – 5.245.6 сая төгрөг

Төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөндөө бүртгэх зөвшөөрөл хүссэн байгууллагуудын хүсэлтийг комиссын хурлаар хэлэлцүүлж, давхардсан тоогоор **124** байгууллагын **5,245.6 сая** төгрөгийн эд хөрөнгийг бүртгэсэн.

Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авах тухай албан бичиг хүргүүлсэн байдал –17 580.5 сая төгрөг

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, нийслэлийн Автозамын хөгжлийн газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба зэрэг захиалагч байгууллага болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгөөр бий болсон шугам сүлжээ, автозам, тохижилт, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлтийг үндэслэн шинээр бий болсон 197 төсөл арга хэмжээний нийт 17 580,5 сая төгрөгийн эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгаж, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг даалгасан 65 албан бичгийг өмч эзэмшигч 26 байгууллагад хүргүүлсэн байна.



3.2.2. Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн талаар:

Дээрх ажлын хүрээнд нийт **6,974.8 сая** төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын балансад шилжүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлсэн байна. Үүнд:

А. Нийслэлийн Засаг даргын захирамжаар:

- Нийслэлийн Засаг даргын А/125, А/130, А/487, А/707, А/709, А/857, А/880, А/1031 тоот захирамжаар **5,103.5 сая** төгрөгийн хөрөнгө балансаас балансад шилжсэн байна.

Барилга байгууламж	1,384.9 сая төгрөг
Тээврийн хэрэгсэл	2, 138.6 сая төгрөг
Тоног төхөөрөмж	1,580 сая төгрөг

Б. Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцах комиссын хуралд оруулан шийдвэрлүүлсэн асуудлууд:

- ЭБХХХК-ын шийдвэрээр 50 байгууллагын **1,871.3** сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн байна.

3.2.3. Хөрөнгө данснаас хасч актлах асуудлын талаар:

Тайлант хугацаанд ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 12,417 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасч, актлах асуудлыг судлан, танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулан нийслэлийн өмчийн бүртгэлээс хасуулах шийдвэрийг гаргуулан, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

А. НИТХ-ын тогтоолоор нийт **2,220** сая төгрөгийн хөрөнгө данс бүртгэлээс хасч, актлах шийдвэр гаргуулсан. Үүнд:

➤ НИТХТ-ийн 2019 оны 16 дугаар тогтоолоор Сүхбаатар дүүргийн 10 11 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн 272 сая төгрөгийн үнэ бүхий 2 барилгыг нийслэлийн бүртгэлээс хасах,

➤ НИТХТ-ийн 2019 оны 68-р тогтоолоор дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр тасгийн барилга барих болсонтой холбогдуулан ЧД-ийн Цагдаагийн 2 дугаар хэлтсийн Жигжид зуслан дахь тасгийн 1,0 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгыг акталж, данс бүртгэлээс хасахаар шийдвэрлэв.

➤ НИТХТ-ийн 2019 оны 93 дугаар тогтоолоор Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах цагдаагийн 1 дүгээр хэлтсийн балансад бүртгэлтэй 487,5 сая төгрөгийн өртөгтэй барилга байгууламж акталж, нийслэлийн өмчөөс хасах.

➤ НИТХТ-ийн 2019 оны 96 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барилга барих болсонтой холбогдуулан ЧД-ийн 9-р цэцэрлэг, 37 дугаар цэцэрлэг, 39 дүгээр цэцэрлэг, Баянзүрх дүүргийн 20 дугаар цэцэрлэг, Хан-Уул дүүргийн 121 дүгээр цэцэрлэг, Хан-Уул дүүргийн 134 дүгээр цэцэрлэгийн нийт 967,9 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламжийг акталж, данс бүртгэлээс хасах

➤ НИТХТ-ийн 2019 оны 128 дугаар тогтоолоор “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын дансанд бүртгэлтэй 441,3 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 16 барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчөөс хасах,

➤ НИТХТ-ийн 129 дүгээр тогтоолоор Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 3,4 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий агуулах зоорийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах,

➤ НИТХТ-ийн 2019 оны 165 дугаар тогтоолоор “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй 10,3 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 2 ус түгээх байрыг буулгаж, нийслэлийн өмчөөс хасах,

➤ НИТХТ-ийн 166 дугаар тогтоолоор Баянзүрх дүүргийн 16 дугаар хороонд байрлах 36,9 сая төгрөгийн үнэ бүхий “Насан-Урт” өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахаар шийдвэрлэв.

Б. Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцах комиссын хуралд оруулан шийдвэрлүүлсэн асуудлууд:

Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөдлөх хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасуулах байгууллагуудын хүсэлтийг судлан асуудлыг боловсруулан “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурлаар хэлэлцүүлж, 265 байгууллагын нийт 10,197 сая төгрөгийн эд хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах газрын даргын тушаалыг гаргуулан, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.


3.2.4. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурлыг зохион байгуулах:

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2019.04.30-ны өдрийн А/81, 2019.07.25-ний өдрийн А/267 тоот тушаалаар батлагдсан Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс нь 2019.01.01-ний өдрөөс 12.31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 23 удаа хуралдаж давхардсан тоогоор нийт 662 байгууллагын 11358 нэр төрлийн эд хөрөнгийн худалдан авах, шинээр бүртгэх, балансаас балансад шилжүүлэх, данснаас дансанд шилжүүлэх, данснаас хасах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа. Үүнд:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

1. 124 байгууллагын 2,496,189,335 төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авах,
2. 197 байгууллагын 5,245,649,285 төгрөгийн хөрөнгө бүртгэх,
3. 50 байгууллагын 1,871,394,356 төгрөгийн хөрөнгийг балансаас балансад,
4. 28 байгууллагын 236,940,606 төгрөгийн хөрөнгийг данснаас дансанд шилжүүлэх,
5. 268 байгууллагын 10,786,948,975 төгрөгийн хөрөнгийг данснаас хасах асуудлуудыг комиссын хурлаар тус тус шийдвэрлэсэн байна.

Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөнийг графикаар тус тус үзүүлвэл:



Дээрх графикаас харахад данснаас хасах хөрөнгийн хөдөлгөөн 52%, хөрөнгө бүртгэх 25%, худалдан авах 12%, балансаас балансад шилжүүлэх 9%, данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн хөдөлгөөн 1%-тай байна.


ЭБХХХК-ын 23 удаагийн хурлын хөрөнгийн хөдөлгөөний дүн:



Хөрөнгийн хөдөлгөөнийг улирлаар харуулбал:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

	Байгууллагын тоо	Худалдан авах дүн	Байгууллагын тоо	Бүртгэх дүн	Байгууллагын тоо	Балансаас балансад шилжүүлэх дүн	Байгууллагын тоо	Данснаас хасах дүн	Байгууллагын тоо	Данснаас дансанд шилжүүлэх	Нийт байгууллагын тоо	Нийт хөрөнгийн дүн
1-р улирал	4	21,273,650	16	541,675,470	9	106,493,299	20	830,929,913		-	49	1,500,372,332
2-р улирал	18	403,754,167	21	197,459,988	10	444,614,040	73	2,989,425,402	1	31,057,813	123	4,066,311,410
3-р улирал	8	134,813,900	30	461,085,726	9	489,253,967	39	963,684,349	3	6,291,549	89	2,055,129,491
4-р улирал	94	1,936,347,618	130	4,045,428,101	22	831,033,050	131	6,002,909,311	24	199,591,244	401	13,015,309,324
	124	2,496,189,335	197	5,245,649,285	50	1,871,394,356	263	10,786,948,975	28	236,940,606	662	20,637,122,557



Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын ажиллах журмыг шинэчлэн газрын даргын 2019.12.12-ны өдрийн А/578 дугаар тушаалаар батлуулж ажилласан.

Хөрөнгийн хөдөлгөөнийг 2018 онтой харьцуулбал:



3.2.5. Тээврийн хэрэгслийн дуудлага худалдааны талаар:

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172, А/1105 дугаартай захирамжуудын дагуу тээврийн хэрэгслийн нээлтэй дуудлагын худалдааны зарыг боловсруулан “Монголын үнэн” “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” зэрэг өдөр тутмын сонинд 3 удаа байршуулсан.

- 2019.03.07-ны дугаарт нийт 21 байгууллагын 27 тээврийн хэрэгсэл худалдах зар
- 2019.05.14-ний дугаарт нийт 7 байгууллагын 9 тээврийн хэрэгсэл худалдах зар
- 2019.10.28-ны дугаарт нийт 17 байгууллагын 47 тээврийн хэрэгсэл худалдах зар

Тээврийн хэрэгслийн дуудлагын худалдааг 3 удаа зохион байгуулж нийт 22 байгууллагын 29 тээврийн хэрэгслийг дуудлагаар худалдаж давхардсан тоогоор 29 иргэнтэй худалдах худалдан авах гэрээг байгуулж, худалдан авагчид автомашиныг хүлээлгэн өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж 72,7 сая төгрөгөөр худалдан борлуулж нийслэлийн төсөвт **56,9 сая** төгрөгийн орлого оруулсан.

Нийслэлийн Засаг даргын захирамжаар сэлбэг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулж байгаа 22 байгууллагын 82 тээврийн хэрэгслийг данснаас хасах 22, эзэмшигч байгууллагад нь сэлбэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэгдсэн 4 байгууллагын 5 тээврийн хэрэгслийг данснаас хасах 4, мөн дуудлагын худалдаагаар зарагдсан 17 байгууллагын 20 тээврийн хэрэгслийг данснаас хасах 17 тушаал нийт 43 тушаалыг харьяалагдах байгууллагуудад нь хүргүүлсэн байна.

3.3. Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэсэн талаар

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам”-ын дагуу нийслэлийн өмчит 704 байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээний 2018 оны биелэлтийг дүгнэсэн.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019.05.27-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2018 оны биелэлтийг дүгнэж үнэлэлт дүгнэлт өгөх үүрэг бүхий ажлын хэсэг томилогдон тушаал шийдвэрийн биелэлт, хөрөнгийн хөдөлгөөн, санхүүгийн тайлан, хөрөнгийн бүртгэл, хөтлөлт тайлагналт, түрээсийн төлбөр тооцоо зэрэг 4 багц бүхий 13 үзүүлэлтээр 100 хүртэл оноогоор дүгнэв.

Нийслэлийн төсөвт нийт 718 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмч эзэмшлийн гэрээний 2018 оны биелэлтийг дүгнэх ажилд 713 байгууллага хамрагдахаас **98,7%** хувь буюу 704 байгууллага хамрагдлаа.

Нийслэлийн өмч эзэмшүүлэх гэрээ дүгнэх ажилд хамрагдаагүй, дүгнэгдээгүй нийт 14 байгууллага байна. Тодруулбал:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

- Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй болон шинээр байгуулагдсан мөн үйл ажиллагаа нь эхлээд удаагүй Баянзүрх дүүргийн 146, 256, 257 дугаар цэцэрлэгүүд, Сонгинохайрхан дүүргийн 260, 261 дүгээр цэцэрлэг,
- Нийслэлийн засаг даргын 2019 оны А/241 дүгээр захирамжаар Нийслэлийн Хүүхэд гэр бүл хөгжлийн газрын үйл ажиллагааг Нийслэлийн Залуучууд хөгжлийн газарт нэгтгэж Нийслэлийн гэр бүл хүүхэд, Залуучуудын газартай, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/18, А/41 дүгээр тушаалаар Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны “Өөдрөг энх” ӨЭМТ-ийг 5 дугаар хорооны “Түвшин хүч” ӨЭМТ-тэй, 1 дүгээр хорооны “Тэгш саруул” ӨЭМТ-ийг 2 дугаар хорооны “Ачит гар” ӨЭМТ-тэй тус тус нэгтгэн зохион байгуулсан.
- Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулаагүй байгууллага Нийслэлийн Соёлын төв өргөө, Сүхбаатар дүүргийн Спорт хороо,
- Шалтгаангүйгээр дүгнүүлээгүй Багануур дүүргийн 1 дүгээр хорооны “Энэрэлт өлзий” ӨЭМТ, 3 дугаар хорооны “Биваангирд” ӨЭМТ, Баянгол дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс,
- 2018 онд барилга нь актлагдаж үйл ажиллагаа явуулаагүй Сүхбаатар дүүргийн 24 дүгээр цэцэрлэг

Гэрээ дүгнэх ажилд хамрагдсан нийт 704 байгууллагын 77,8% буюу 548 байгууллага “Бүрэн хангалттай”, 20,1% буюу 142 байгууллага “Хангалттай”, 2,1% буюу 14 байгууллага “Ажил сайжруулах” гэсэн үнэлгээ авч, 9 байгууллага гэрээний үүргийн биелэлтээ дүгнүүлээгүй болно.

Нэгдсэн дүнг хүснэгтээр үзүүлбэл:

№	Үнэлгээ	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД	НТЗБ	НӨТҮГ	Нийт
1	Бүрэн хангалттай	26	12	87	106	22	100	55	43	60	25	12	548
2	Хангалттай	2	5	2	17	14	19	26	35	16	6	-	141
3	Ажил сайжруулах	-	-	2	-	-	1	2	7	2	-	-	15
4	Хангалтгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0
5	Дүгнэгдээгүй	2	-	1	3	-	2	4	-	-	2	-	14
	Нийт	30	17	92	126	36	122	87	85	78	33	12	718

Удирдлага нь “Ажил сайжруулах” үнэлгээ авсан байгууллагуудад Нийслэлийн мал эмнэлгийн газар, Баянгол дүүргийн 2 хорооны “Илаарших” ӨЭМТ, Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны “Эрүүл жаргал” ӨЭМТ, Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны “Энхийн санаа” ӨЭМТ, 13 дугаар хорооны “Санколл” ӨЭМТ, Хан-Уул дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжлийн төв, Соёлын төв, Хан-Уул агро ОНӨААТҮГ, 63 дугаар сургууль, 134 дүгээр цэцэрлэг, 209 дүгээр цэцэрлэг, Чингэлтэй дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Албан бус насан туршийн боловсролын төв орж байна. “Хангалтгүй” үнэлгээ авсан байгууллага байхгүй.

Дээрх байгууллагуудаас ажил сайжруулах үнэлгээ авсан болон эрсдэл өндөртэй 9 дүүргийн 77 байгууллагыг түүвэрчлэн тухайн байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгийн зарцуулалт, бүртгэлд хяналтад шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг 2019.09.30-ны өдрийн А/348 дугаар тушаалаар байгуулсан.

Шалгалтад хамрагдсан нийт 74 байгууллагын 44% буюу 32 байгууллага 1-17 тооны нийт 81,9 сая төгрөгийн хөрөнгийн дансны ангиллыг буруу хөтөлсөн, 26% буюу 19 байгууллага хөрөнгийн нэршлийг буруу бичсэн, 22% буюу 16 байгууллага эд хөрөнгө ашиглагчийн картанд ашиглаж буй хөрөнгийг дутуу бүртгэсэн, эд хариуцагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй, хөрөнгийг бүрэн коджуулаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, хөрөнгийн дансны ангиллын зөрчил өндөр хувьтай байна.

Өмч хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт хамгаалтын байдлыг сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн ажлыг авч үзвэл шалгалтанд хамрагдсан байгууллагуудын 44% буюу 32 байгууллага Өмч хамгаалах байнгын зөвлөлийг хуулийн дагуу томилоогүй, тухайн оны ажлаа төлөвлөөгүй, хийсэн ажлаа бүрэн гүйцэд тайлагнаагүй, Өмч хамгаалах байнгын зөвлөлийг хуралдуулж хурлын тэмдэглэл хөтлөөгүй зэрэг давхардсан тоогоор 41% буюу 30 байгууллага байгаа нь өмч хөрөнгийг үрэгдэж алга болох нөхцлийг бүрдүүлж байна.

Ажлын хэсгийн шалгалтын нэгдсэн дүнг нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан.

3.4. Нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний ажлын талаар

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 193 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Сангийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, аймаг нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан. Сангийн сайдын 2018.08.07-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 207 дугаар тушаалаар дахин үнэлгээ хийх, нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018.08.14-ний өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг зохион байгуулах тухай” 367 дугаар тогтоолоор үнэлгээний ажлыг зохион байгуулах заавар тус тус батлагдан гарсан ба төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээнд хамрагдсан нийслэлийн 100 хувийн өмчтэй 520 байгууллагын үнэлгээний тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас боловсруулсан маягтын дагуу хяналтын хуудсаар хүлээн авч, аймаг, нийслэлийн нэгдсэн дүнг гаргах маягтын дагуу нийслэлийн дүнг нэгтгэн гаргав.

Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөрөнгийн дахин үнэлгээнд хамрагдсан байгууллагуудыг үзүүлбэл:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

№	Дүүргийн нэр	Дахин үнэлгээнд хамрагдсан						ДҮН
		Цэцэрлэг	Сургууль	ӨЭМТ	Эрүүл мэндийн байгууллага	Төр захиргааны болон бусад төсөвт байгууллага	Үйлдвэрийн газар, компани	
1	Багануур	9	3		2	8	5	27
2	Багахангай	2	1		1	6	3	13
3	Баянгол	32	17	2	3	8	6	68
4	Баянзүрх	38	23	3	5	10	11	90
5	Налайх	7	5		1	8	6	27
6	Сонгинохайрхан	40	18	9	4	8	7	86
7	Сүхбаатар	31	17	4	4	9	7	72
8	Хан-Уул	24	17	5	3	8	7	64
9	Чингэлтэй	26	15	3	1	20	8	73
	ДҮН	209	116	26	24	85	60	520

Нийслэлийн өмчит 478 хуулийн этгээдийн эзэмшилд буй 1255 нэгж талбарын 42538565,7 м2 буюу 4253,9 га газар 893 743,2 сая төгрөгөөр үнэлэгдэв.

Нийслэлийн өмчийн барилга байгууламжийн 2018 оны бүртгэл, үнэлгээний нэгтгэлд 515 хуулийн этгээдийн 23,970 нэрийн 1,292,267,4 сая төгрөгийн /1292267397497,9 төг/ үлдэх өртөгтэй хөрөнгө нэгтгэгджээ.

Нийслэлийн өмчийн барилгын дахин үнэлгээний үр дүнд онцгой анхаарч, дэлгэрэнгүй судалж үзвэл нийслэлийн өмчит 438 хуулийн этгээд эзэмшилдээ буй 2652 барилга үнэлсэн байна.

Барилгын дахин үнэлгээний үр дүнг дүүрэг тус бүрээр үзүүлье.

БАГАНУУР	Цэцэрлэг	Сургууль	ӨЭМТ	Эрүүл мэнд	Төр захиргааны болон бусад төсөвт байгууллага	ЗДТГ	Үйлдвэрийн газар, компани	Дүн
Хуулийн этгээдийн тоо	7	3		2	6	1	4	23
Барилгын тоо	9	10		19	21	8	49	116
Үүнээс: үндсэн үйл ажиллагаа явуулж буй	8	6		3				17
Үлдэх өртөг	4,317,580,136.2	8,395,772,426.1		6,365,258,050.8	2,114,507,544.4	1,658,568,539.7	4,057,618,029.1	26,909,304,726.3
Бодит үнэ цэнэ	10,631,945,675.6	18,460,845,923.0		15,152,489,469.1	5,330,459,124.9	5,774,812,949.6	6,301,125,434.5	61,651,678,576.7
Дахин үнэлгээний нэмэгдэл	6,314,365,539.3	9,743,123,738.5		8,786,298,862.4	3,075,737,711.5	4,116,244,409.9	2,243,507,405.4	34,279,277,667.1
Цаашид ашиглах дундаж хугацаа	9.13	24.00		22.53	23.48	37.25	25.86	20.3
Хуучин элэгдлийн дундаж								40.88
Шинээр тооцсон элэгдлийн дундаж								43.65

СҮХБААТАР	Цэцэрлэг	Сургууль	ӨЭМТ	Эрүүл мэнд	Төр захиргааны болон бусад төсөвт байгууллага	ЗДТГ	Үйлдвэрийн газар, компани	Дүн
Хуулийн этгээдийн тоо	30	16	4	4	7	1	6	68
Барилгын тоо	48	48	4	24	64	30	25	243
Үүнээс: үндсэн үйл ажиллагаа явуулж буй	35	23	4	15				77
Үлдэх өртөг	12,077,288,622.5	28,609,191,749.4	525,186,728.6	18,712,091,767.4	15,240,926,511.4	12,064,097,952.9	10,145,429,871.6	97,374,213,203.8
Бодит үнэ цэнэ	21,856,395,877.1	47,944,355,401.9	635,238,205.9	30,116,475,713.8	53,466,532,880.6	11,959,468,407.0	14,694,234,014.3	180,672,700,500.6
Дахин үнэлгээний нэмэгдэл	10,889,192,006.5	14,785,315,107.3	120,753,990.0	13,142,338,809.4	37,857,638,863.1	(104,629,545.9)	4,548,804,142.7	81,239,413,373.2
Цаашид ашиглах дундаж хугацаа	27.00	27.47	32.00	28.96		32.76	22.67	24.4
Хуучин элэгдлийн дундаж								42.74
Шинээр тооцсон элэгдлийн дундаж								40.29

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

СОНГИНОХАЙРХАН	Цэцэрлэг	Сургууль	ӨЭМТ	Эрүүл мэнд	Төр захиргааны болон бусад төсөвт байгууллага	ЗДТГ	Үйлдвэрийн газар, компани	Дүн
Хуулийн этгээдийн тоо	39	16	8	4	4	1	5	77
Барилгын тоо	69	53	11	27	17	42	10	229
Үүнээс: үндсэн үйл ажиллагаа явуулж буй	46	32	3	14				
Үлдэх өртөг	17,793,408,521.2	40,405,377,768.3	665,628,260.9	4,928,797,913.7	770,910,761.9	10,289,504,633.0	1,772,645,096.0	76,626,272,955.0
Бодит үнэ цэнэ	40,312,985,092.6	55,796,252,720.9	1,109,873,371.9	13,691,821,459.7	2,125,558,330.5	10,896,046,801.7	1,547,112,852.5	125,479,650,629.8
Дахин үнэлгээний нэмэгдэл	21,681,980,008.3	14,351,245,604.0	444,245,177.0	8,543,554,459.7	1,354,647,568.6	(3,684,068,187.3)	(225,532,243.8)	42,466,072,386.6
Цаашид ашиглах дундаж хугацаа	33.48	33.57	25.83	18.54	15.19	46.20	20.60	27.6
Хуучин элэгдлийн дундаж								38.24
Шинээр тооцсон элэгдлийн дундаж								40.03

БАГАХАНГАЙ	Цэцэрлэг	Сургууль	ӨЭМТ	Эрүүл мэнд	Төр захиргааны болон бусад төсөвт байгууллага	ЗДТГ	Үйлдвэрийн газар, компани	Дүн
Хуулийн этгээдийн тоо	2	1		1	5	1	3	13
Барилгын тоо	5	7		7	7	11	17	54
Үүнээс: үндсэн үйл ажиллагаа явуулж буй	4	3		1				8
Үлдэх өртөг	1,116,075,872.5	1,132,454,572.1		206,909,622.7	447,906,763.1	759,263,723.2	285,877,931.6	3,948,488,485.2
Бодит үнэ цэнэ	1,615,585,522.0	2,127,616,085.6		339,386,521.8	1,013,079,318.8	2,029,789,536.3	561,542,819.9	7,686,999,804.4
Дахин үнэлгээний нэмэгдэл	499,509,649.5	995,161,513.5		132,292,211.7	565,172,555.7	1,270,525,813.2	263,262,800.1	3,725,924,543.6
Цаашид ашиглах дундаж хугацаа	29.25	32.14			26.43	38.55	27.12	21.9
Хуучин элэгдлийн дундаж								37.47
Шинээр тооцсон элэгдлийн дундаж								37.61

ХАН-УУЛ	Цэцэрлэг	Сургууль	ӨЭМТ	Эрүүл мэнд	Төр захиргааны болон бусад төсөвт байгууллага	ЗДТГ	Үйлдвэрийн газар, компани	Дүн
Хуулийн этгээдийн тоо	17	15	5	3	7	1	4	52
Барилгын тоо	26	34	5	12	10	22	49	158
Үүнээс: үндсэн үйл ажиллагаа явуулж буй	18	20	4	6				48
Үлдэх өртөг	6,470,463,463.0	15,146,169,298.4	476,869,346.1	3,632,758,640.4	2,938,836,665.3	8,993,112,572.5	9,003,948,303.9	46,662,158,289.6
Бодит үнэ цэнэ	9,439,860,256.5	19,538,230,246.3	372,360,648.8	7,939,808,694.5	4,557,099,935.9	12,488,118,321.5	19,003,050,706.8	73,338,528,810.3
Дахин үнэлгээний нэмэгдэл	2,882,468,032.8	4,160,508,953.9	143,954,542.9	4,288,428,287.9	2,040,506,982.8	3,495,005,749.0	9,999,102,402.8	27,009,974,952.1
Цаашид ашиглах дундаж хугацаа	22.58	25.77		27.42	32.10		29.23	19.6
Хуучин элэгдлийн дундаж								42.02
Шинээр тооцсон элэгдлийн дундаж								39.66

НАЛАЙХ	Цэцэрлэг	Сургууль	ӨЭМТ	Эрүүл мэнд	Төр захиргааны болон бусад төсөвт байгууллага	ЗДТГ	Үйлдвэрийн газар, компани	Дүн
Хуулийн этгээдийн тоо	6	5		1	4	1	5	22
Барилгын тоо	16	10		9	9	19	56	119
Үүнээс: үндсэн үйл ажиллагаа явуулж буй	10	6		4				20
Үлдэх өртөг	998,793,739.0	7,246,162,284.5		2,081,231,683.6	477,529,329.0	2,678,710,252.2	456,378,841.2	13,938,806,129.5
Бодит үнэ цэнэ	3,908,685,707.1	14,704,836,773.7		5,504,386,187.9	1,676,390,705.6	3,702,302,352.2	1,723,539,954.2	31,220,141,680.7
Дахин үнэлгээний нэмэгдэл	2,817,275,400.0	7,458,674,489.2		3,423,154,504.3	1,181,069,886.8	1,023,592,100.0	1,267,161,113.1	17,170,927,493.3
Цаашид ашиглах дундаж хугацаа	23.38	28.30		13.00	19.33	31.84		16.6
Хуучин элэгдлийн дундаж								51.12
Шинээр тооцсон элэгдлийн дундаж								48.36

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

БЯАНЗҮРХ	Цэцэрлэг	Сургууль	ӨЭМГ	Эрүүл мэнд	Төр захиргааны болон бусад төсөвт байгууллага	ЗДТГ	Үйлдвэрийн газар, компани	Дүн
Хуулийн этгээдийн тоо	32	19	1	3	8	1	10	74
Барилгын тоо	54	49	1	10	39	43	757	953
Үүнээс: үндсэн үйл ажиллагаа явуулж буй	38	41	1	6				
Үлдэх өртөг	14,224,902,710.3	30,919,635,740.5	15,729,685.3	2,353,134,370.1	13,011,291,595.9	10,475,694,147.4	23,489,873,926.5	94,490,262,176.0
Бодит үнэ цэнэ	25,216,943,734.6	48,175,621,291.8	15,307,971.0	2,971,314,285.7	17,405,043,857.0	15,349,056,331.3	20,253,516,073.5	129,386,803,544.9
Дахин үнэлгээний нэмэгдэл	10,659,299,741.9	15,033,098,745.6	(421,714.3)	618,179,915.6	4,388,283,891.7	4,873,362,184.0	(3,604,462,997.1)	31,967,339,767.3
Цаашид ашиглах дундаж хугацаа	27.75	32.56	6.00	12.10	20.67	41.23	25.31	23.7
Хуучин элэгдлийн дундаж								53.06
Шинээр тооцсон элэгдлийн дундаж								45.07

ЧИНГЭЛТЭЙ	Цэцэрлэг	Сургууль	ӨЭМГ	Эрүүл мэнд	Төр захиргааны болон бусад төсөвт байгууллага	ЗДТГ	Үйлдвэрийн газар, компани	Дүн
Хуулийн этгээдийн тоо	17	12	3	1	12	1	7	53
Барилгын тоо	25	26	5	4	52	47	469	628
Үүнээс: үндсэн үйл ажиллагаа явуулж буй	22	20	3	4				
Үлдэх өртөг	4,341,354,617.8	7,338,044,045.6	241,356,928.5	1,963,931,438.0	9,688,494,676.7	7,825,630,319.0	16,899,448,447.0	48,298,260,472.6
Бодит үнэ цэнэ	14,389,728,259.4	21,598,725,752.0	260,876,615.0	3,384,106,468.9	19,454,970,212.7	11,294,214,519.7	23,830,939,464.5	94,213,561,292.2
Дахин үнэлгээний нэмэгдэл	4,416,805,636.1	11,529,903,980.0	(4,438,821.1)	(1,962,731,688.2)	10,631,548,029.0	3,468,584,200.8	5,935,589,427.7	34,015,260,764.2
Цаашид ашиглах дундаж хугацаа	30.03	26.17	25.40	25.25	15.55	37.32	33.53	27.6
Хуучин элэгдлийн дундаж								30.41
Шинээр тооцсон элэгдлийн дундаж								39.87

БЯАНГОЛ	Цэцэрлэг	Сургууль	ӨЭМГ	Эрүүл мэнд	Төр захиргааны болон бусад төсөвт байгууллага	ЗДТГ	Үйлдвэрийн газар, компани	Дүн
Хуулийн этгээдийн тоо	27	16	2	3	4	1	3	56
Барилгын тоо	32	32	2	6	18	50	12	152
Үүнээс: үндсэн үйл ажиллагаа явуулж буй	28	27	1	5				61
Үлдэх өртөг	20,533,303,522.4	30,355,084,480.4	73,872,903.3	10,887,400,507.6	2,553,304,145.6	10,503,787,690.2	2,980,380,817.2	77,887,134,066.7
Бодит үнэ цэнэ	44,049,628,199.2	53,813,153,411.3	56,765,559.5	14,025,654,595.4	4,372,276,009.3	11,574,339,540.6	2,832,425,742.1	130,724,243,057.4
Дахин үнэлгээний нэмэгдэл	26,175,279,847.3	26,681,472,532.5	(17,107,343.8)	3,138,254,087.9	1,365,444,344.0	1,070,551,850.4	(147,955,075.1)	58,265,940,243.2
Цаашид ашиглах дундаж хугацаа	29.84	25.73		24.50	27.25	35.48	28.08	24.4
Хуучин элэгдлийн дундаж								39.73
Шинээр тооцсон элэгдлийн дундаж								43.18

Нийслэлийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019.07.04-ний өдрийн 118 дугаар тогтоолоор баталгаажуулан, Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2019.07.10-ны өдрийн 3/833 дугаар албан бичгээр холбогдох тогтоол, нэгдсэн тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.

Дахин үнэлгээний дүнг баталгаажуулсан тогтоолын 2 дугаар заалтаар дахин үнэлгээний ажлын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар холбогдох арга хэмжээг зохион байгуулан ажиллахыг үүрэг болгосны дагуу нийслэлийн өмчийн бүртгэлд тусгагдаагүй байсан **24,945,6 сая** төгрөгийн 14 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авах тогтоолын төсөлд санал авч байна.

3.5. Өмч хувьчлалын ажлын талаар

3.5.1. 2019 онд өмч хувьчлалын ажлын талаар хийсэн ажлууд:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/21 дүгээр тогтоолоор 2019 онд 2 аж ахуйн нэгж, 13 барилга байгууламжийг хувьчилж, нийслэлийн төсөвт 90,1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр баталсан. Орлогын төлөвлөгөөний дийлэнх буюу 94,4 хувь болох 85,0 тэрбум төгрөгийг “Хангарьд” ордон /40,0 тэрбум/, нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр /20,0 тэрбум/, хуучнаар “Автобус 3” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын барилга байгууламж /25,0 тэрбум/-ийг хувьчилж, орлогыг төвлөрүүлэхээр тооцоолсон. /Хуучнаар “Автобус 3” НӨҮГ-ын барилга байгууламжийг НИТХ-ын 2015 оны 24/05 дугаар тогтоолоор хувьчлахаар шийдвэрлэсэн/

Мөн хувьчлалын бэлтгэл ажлын хүрээнд “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ, “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын Ахуйн үйлчилгээний төв, Багахангай Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ-уудыг менежментийн гэрээгээр ажиллуулах этгээдийг сонгон шалгаруулах журам, гэрээний төслийг боловсруулж, НИТХТ-ийн 2019.03.22-ны өдрийн 45, 46, 47, 48 дугаар тогтоолуудаар батлуулсан болно.

Нийслэлийн өмчөөс 2019 онд хувьчлагдах аж ахуйн нэгж, барилга байгууламжуудад мэргэжлийн байгууллагуудаар бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийлгэв.

Хуулийн этгээд эд, хөрөнгийн нэр	Үнэлгээ хийсэн компанийн нэр	Үнэлгээний дүн	Гэрээний дугаар, ажлын хөлс
“Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ	“Файн эстимэйт” ХХК	881 550 000	№1/2018 2 200 000
“Чандмань налайх” ОНӨААТҮГ-ын ахуй үйлчилгээний төв СБД-ийн 16-р хорооны ийн хуучин барилга	“Ю би пропертиз” ХХК	180 000 000	№2/2018 3 500 000
		55 080 000	
“Монгол шуудан” ХК-ийн 23-р салбарын түрээсээр эзэмшиж байсан байрны 2 дах хэсэг БНД-ийн 2-р хорооны хуучин барилга	“Бэсгэ” ХХК	250 610 453 000	№3/2018 1 250 000
		34 113 125	
БЗД-ийн Цагдаагийн 3 дугаар хэлтсийн Шар хадны хэсгийн хуучин барилга СХД-ийн 20 дугаар хорооны халуун усны барилга	“Лэндс” ХХК	102 256 874	№4/2018 1 100 000
		100 671 573	

Хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн хувьчлалын ажлыг хариуцан ажиллах Итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг нийслэлийн Засаг даргын 2019.02.25-ны өдрийн А/126 дугаар захирамжаар томилуулсан ба НИТХТ-ийн 2019.06.10-ны өдрийн 95 дугаар тогтоолоор нийслэлийн Өмч хувьчлах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулав.

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлыг 2019.07.05-ны өдөр зохион байгуулсан ба хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэсэн. Үүнд:

1. Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах үралдаант шалгаруулалтын хуваарийг батлуулах:

-“Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ,

-“Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын ажиллуулж буй 8 хүний халуун ус бүхий үйлчилгээний төв,

2. Шинээр хувьчлах:

-БЗД-ийн Цагдаагийн 3 дугаар хэлтсийн Шар хадны хэсгийн хуучин барилгыг 102,3 сая төгрөгөөр,

-СБД-ийн 16 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн хуучин барилгыг 55,0 сая төгрөгөөр,

-БНД-ийн 2 дугаар хорооны хуучин барилгыг 34,1 сая төгрөгөөр,

“Монгол шуудан” ХК-ийн 23 дугаар салбарын түрээсээр эзэмшиж байсан байрны 2 дугаар хэсгийг 250,6 сая төгрөгөөр,

-“Монгол шуудан” ХК-ийн 23 дугаар салбарын түрээслэж буй байрыг 214,8 сая төгрөгөөр,

-Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны Халуун усны барилгыг 100,7 сая төгрөгөөр,

-ХУД-ийн 12 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн хуучин барилгыг 62,2 сая төгрөгөөр,

-СБД-ийн 10 дугаар хорооны Халуун усны барилгыг 252,3 сая төгрөгөөр,

3. Дүүдлагын худалдааг дахин явуулах тухай:

-БГД-ийн 10 дугаар хорооны хуучин барилгын анхны үнийг 30,0 хувиар бууруулж 24,5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоох,

-БЗД-ийн 9 дүгээр хорооны хуучин барилгын анхны үнийг 30,0 хувиар бууруулж 76,6 сая төгрөгөөр,

4. Өмчлөгчийн эрх олгох тухай:

-ХУД-ийн 6 дугаар хороонд байрлах Цагдаагийн түр саатуулах байрлаж байсан барилгын өмчлөх эрхийг хувьчилж авсан иргэнд шилжүүлэх,

5. Хувьчлалын тайланг батлах тухай:

-“Усан спорт сургалтын төв” ОНӨААТҮГ-ыг хувьчилсан тухай тайлан,

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2019.07.05-ны өдрийн хурлаар өмчлөгчийн эрх олгох тухай, хувьчлалын тайлан батлах тухай 2 асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд комиссын хурлаас тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2019.07.30-ны өдрийн 3/939 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, 2019.08.29-ны өдрийн 3/1134 дүгээр албан бичгээр Газар зохион байгуулалтын албанд тус тус хүргүүлсэн. Мөн хурлаас өгсөн үүргийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулах буюу тендерийн хуваарийг батлахтай холбогдуулан “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаатай нарийвчлан танилцах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэгтэй Ажлын хэсгийг Газрын даргын 2019.07.18-ны өдрийн А/260 дугаар тушаалаар байгуулсан ба Ажлын хэсэг 2019.07.19-21-ний өдрүүдэд Булган аймгийн Хялганат тосгонд ажиллаж, үйлдвэрийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл, өнөөгийн нөхцөл байдлыг судлан, санал дүгнэлт гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн.



Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар хэлтсийн ахлах, өмч хувьчлалын мэргэжилтэн Ч.Мөнхбаяр ажилласан болно.

Мөн хувьчлах эд хөрөнгийн жагсаалтанд орсон боловч, тодорхой шалтгааны улмаас хойшлогдсон нийт 34 аж ахуйн нэгж, барилга байгууламжийн дэлгэрэнгүй тайлбар бүхий жагсаалт, танилцуулга, Улаанбаатар хотод 1990-2018

онуудад хувьчлагдсан аж ахуйн нэгж, барилга байгууламжийн талаар байгууллагын архивт байгаа баримт бичгүүдийг судалж, нэгдсэн жагсаалт гаргаж, цахим архив үүсгэсэн болно.

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын ажиллах журмын 2.3–д заасныг үндэслэн хуралдааны бус хэлбэрээр 3 асуудлыг шийдвэрлүүлэв. Үүнд:

- **Нийслэлийн засаг захиргааны 4 дүгээр байр**

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2019.09.26-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байрыг хувьчлах дуудлагын худалдааны доод үнийг 24,1 тэрбум төгрөгөөр тогтоож, нээлттэй дуудлагын худалдааг нийтэд



зарлахаар шийдвэрлэсний дагуу дуудлагын худалдааг 2019.10.28, 2019.11.12, 2019.11.28-ны өдрүүдэд, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2017.06.07-ны өдрийн 16 дугаар тогтоолоор хуучнаар “Автобус-3” НӨҮГ-ын барилга байгууламжийн дуудлагын худалдааны доод үнийг 26,4 тэрбум төгрөгөөр тогтоосны дагуу 2017.09.28, 2019.11.08, 2019.11.28-ны өдөр дуудлагын худалдааг зохион байгуулахаар

нийтэд зарласан боловч оролцогчийн санал ирээгүй болно.

Нээлттэй дуудлагын худалдааны зар мэдээг “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Үндэсний шуудан” зэрэг өдөр тутмын сониноор нийтэд зарлаж, Өмчийн ашиглалт, удирдлагын газрын “Umch.ub.gov.mn” сайтад байршуулсан. Мөн томоохон барилга байгууламжууд дээр видео зар сурталчилгааг хийлгэн UBS, TV9, SBN, TM зэрэг телевизээр өдрийн 3-5 удаагийн давтамжтайгаар явуулсан.

- **Баянгол дүүргийн 7 дугаар хороо, “Монгол шуудан” ХК-ийн 23 дугаар салбарын түрээсээр эзэмшиж буй байр**

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2019.12.12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Баянгол дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэр, 4 дүгээр хорооллын эцэст байрлах “Монгол шуудан” ХК-ийн 23 дугаар салбарын эзэмшиж буй байрыг 214 302 000 төгрөгөөр тогтоож, Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу түрээсээр эзэмшиж буй “Монгол шуудан” ХК-д тэргүүн ээлжинд санал болгон хувьчлахаар шийдвэрлэсэн.

Тогтоолын дагуу 2019.12.12-ны өдрийн 3/1821 дүгээр албан бичгээр “Монгол шуудан” ХК-д мэдэгдэл хүргүүлсэн ба иргэн “Монгол шуудан” ХК нийт төлбөрөө

төлсний дагуу “Худалдах, худалдан авах гэрээ”-г 2019.12.17-ний өдөр байгуулаад байна.

- **Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны халуун усны барилга**

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2019.12.06-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны халуун усны барилгын хувьчлах үнийг 100,7 сая төгрөгөөр тогтоож, Иргэний хуулийн 105 дугаар зүйлийн дагуу түрээсээр эзэмшиж буй иргэн С.Цэрэнбалжирт тэргүүн ээлжинд санал болгон хувьчлахаар шийдвэрлэсэн.

Тогтоолын дагуу 2019.12.09-ны өдрийн 3/1792 дугаар албан бичгээр иргэн С.Цэрэнбалжирт мэдэгдэл хүргүүлсэн ба иргэн С.Цэрэнбалжир худалдан авахаар дэнчингээ төлж, саналаа ирүүлсэн тул “Худалдах, худалдан авах гэрээ”-г 2019.12.11-ний өдөр байгуулсан.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019.12.02-ны өдрийн хурлаар өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөг тодотгож, 50,2 тэрбум төгрөг болгон өөрчлөлт оруулсан. Тайлант оны өмч хувьчлалын орлогын төлөвлөгөө 0,2 хувийн биелэлттэй байна. Төлөвлөгөө биелээгүй шалтгаан нь орлогын төлөвлөгөөний дийлэнх хувийг бүрдүүлэхээр тооцоолсон томоохон объектуудыг чөлөөлж, дуудлагын худалдааг нь зарлах боломжгүй байсан явдал юм. Энэ оны эхний дуудлагын худалдааг 2019.10.28-ны өдөр зохион байгуулахаар нийтэд зарласан.



Тодорхой шалтгаанаар хувьчлал нь явагдах боломжгүй байгаа буюу тухайлбал газар эзэмших эрхийн зөрчилтэй "Ану сервис" ХХК-ийн менежментийн гэрээгээр ажиллуулж буй халаалтын 8 зуухны барилга байгууламж, Сүхбаатар дүүргийн 10 дугаар хорооны халуун усны барилга, Баянгол дүүргийн 8 дугаар хорооны өрхийн эмнэлгийн хуучин барилга, мөн дүүргийн 20 дугаар хорооны халуун усны барилга, цагдаагийн хэсгийн байр, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх агуулахын барилгын зөрчлийг арилгуулахаар Газар зохион байгуулалтын албанд хандаад байна.

3.5.2. Нийслэлийн өмчөөс 2020 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтын талаар:

Нийслэлийн өмчөөс 2020 онд хувьчлах барилга байгууламж, эд хөрөнгийн жагсаалтын төслийг бэлтгэхдээ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн харьяа 33 агентлагаас ирүүлсэн санал, нийслэлийн өмчлөлд зайлшгүй байх шаардлагатай эсэх, ашиглалтын өнөөгийн түвшин, цаашид ашиглах хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан жагсаалтын төслийг боловсруулсан юм.

Хан-Уул дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт шинээр баригдаж буй нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилга ашиглалтад ороогүй байгаа тул “Хангарьд” ордонд үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, нийслэлийн 14 агентлагийг шилжүүлэн байршуулах байргүйгээс тус

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

барилгын хувьчлалыг хойшлуулж, ирэх онд хувьчлахаар тооцоолон, өмч хувьчлалын орлогоос 2020 онд нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөнд тусгаад байна.

Нийслэлийн өмчөөс 2020 онд шинээр 5 барилга байгууламж, нийслэлийн өмчийн оролцоотой нэг компанийн нийслэлийн мэдлийн хувь, “Хангарьд” ордны барилгыг хувьчилж, өмч хувьчлалын орлогыг 68,363,3 сая төгрөгөөр тогтоосон болно. *Нийслэлийн өмчөөс 2020 онд хувьчлах барилга байгууламжийн жагсаалт:*

№	Хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн нэр, байршил	Байршил	Хувьчлалын арга хэлбэр
1	“Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн нийслэлийн мэдлийн 49 хувь	ХУД-ийн 15-р хороо	Компанийн хуулийн дагуу санал болгон хувьчлах
2	50-р дэлгүүрийн өргөтгөлийн барилга	СБД-ийн 4-р хороо	Нээлттэй дуудлагын худалдаа
3	Баянгол дүүргийн 8 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга	БГД-ийн 8-р хороо	Нээлттэй дуудлагын худалдаа
4	Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга	БГД-ийн 1-р хороо	Нээлттэй дуудлагын худалдаа
5	Монгол шуудан” ХК-ийн 26-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр	БГД-ийн 5-р хороо	Иргэний хуулийн 105-р зүйлийн дагуу санал болгон хувьчлах
6	Монгол шуудан” ХК-ийн 20-р салбарын түрээсээр эзэмшиж буй байр	СБД-ийн 7-р хороо	

3.6. Бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны талаар

3.6.1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан талаар:

Нийслэлийн Засаг даргын 2019.04.04-ны өдрийн А/262 дугаар захирамжаар Баянгол дүүргийн 3 дугаар хороо, Нарны хороололд “960 хүүхдийн ерөнхий боловсролын сургууль, 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын хамт худалдан авах” 18,991,4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсний дагуу Газрын даргын 2019.05.21-ний өдрийн А/120 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан үнэлгээний хороо 2019.05.22-ны өдөр эхний хурлаа хийж бараа нийлүүлэх тендерийн баримт бичгийг боловсруулахад шаардлагатай хөндлөнгийн байгууллагын үнэлгээний тайланг ирүүлэх тухай хүсэлтийг 2019.05.22-ны өдрийн 3/592 дугаар албан бичгээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд, ажлын тоо хэмжээг нарийвчлан боловсруулж ирүүлэх хүсэлтийг 3/593 дугаар тоотой нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, нийслэлийн Боловсролын газарт тус тус хүргүүлэн холбогдох бусад баримт бичиг болох 7 хавтас баримт, тавилга, тоног төхөөрөмжийн жагсаалтыг хүлээн авсан.

Үнэлгээний хорооны 2019.07.23-ны өдөр 2 дах хурлаа хийж баримт бичгүүдийг судлан үзсэний үндсэн дээр уг ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй

тендер шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын дагуу зохион байгуулах боломжгүй гэж үзсэн тул уг ажлыг буцаахаар шийдвэрлэн, Нийслэлийн Засаг даргын 2019.09.30-ны өдрийн А/990 дүгээр захирамжаар хүчингүй болгон дээрх цэцэрлэгийн барилга байгууламжийн үнийг өнөөгийн зах зээлийн жишгийн дагуу бууруулах чиглэлээр хэлэлцээ хийсний үндсэн дээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Ш.Анхмаа даргаар ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсгийн шийдвэрийн дагуу Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019.10.18-ны өдрийн А/369 дүгээр тушаалаар Үнэлгээний хороог байгуулсан ба Үнэлгээний хороо 2019.10.21-ний өдөр хуралдаж тендерийн баримт бичгийг боловсруулан, уламжлалт тендер зарлахаар шийдвэрлэсний дагуу Тендерийн урилгыг 2019.10.22-ны өдрийн “Засгийн газрын мэдээ” сонинд нийтлүүлсэн.

Тендерийг 2019.11.22-ны өдрийн 10:30 цагт нээж, 2019.11.25, 29-ны өдрүүдэд Үнэлгээний хороо хуралдан, тендерийг хянан үзэв.

Үнэлгээний хороо 2019.12.04-ний өдрийн хурлаараа “960 хүүхдийн ерөнхий боловсролын сургууль, 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын хамт худалдан авах, /Баянгол дүүрэг, 3-р хороо, Нарны хороолол/” ажлыг нийлүүлэхээр тендер ирүүлсэн “Гранд слаб” ХХК-тай 18,443,973,000 төгрөгөөр гэрээ байгуулах болсон.

Гэрээ байгуулах зөвлөмжийг 2019.12.04-ний өдрийн “Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлэх тухай” З/1761 дүгээр албан бичгийг “Гранд слаб” ХХК-д, гэрээний төсөл, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн гарын үсэг зурж баталгаажуулахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2019.12.12-ны өдрийн З/1815 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу "Гранд слаб" ХХК-тай ББТТ-2019/01 дугаартай 18,443,973,000.0 төгрөгийн гэрээний захиалагчийн хяналт тавьж, НӨАУГ-ын 2019 оны А/559 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хөрөнгө хүлээн авах ажлыг зохион байгуулан хөрөнгө хүлээлцэх ББТТ-2019/07 дугаар акт, гэрээ дүгнэсэн протокол, гүйцэтгэлийн мэдээг НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2019.12.27-ний 2/1937 тоот албан бичгээр хүргүүлсэн.

3.6.2. Захиалагчийн хяналт тавих ажлын хүрээнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хууль тогтоомжийн дагуу Нийслэлийн Засаг даргын 28 удаагийн захирамжаар нийт 113 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавиж ажилласан байна.

Хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр задалвал:

Эх үүсвэр	Захирамжийн тоо	Бараа, ажил үйлчилгээний тоо	Төсөвт өртгийн дүн, сая төгрөг
Нийслэлийн төсөв	19	99	9 756,1
ОНХС	4	8	210,0
Улсын төсөв	5	6	22 256,4
БҮГД	28	113	32 222,5

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Нийт 113 бараа, ажил үйлчилгээнээс захиалагчийн хяналт тавьж бүрэн хэрэгжүүлсэн:

Эх үүсвэр	Бараа, ажил үйлчилгээний тоо	Төсөвт өртгийн дүн, сая төгрөг
Нийслэлийн төсөв	82	5 757,3
ОНХС	4	170,0
Улсын төсөв	3	715,0
БҮГД	89	6 642,3

Захиалагчийн хяналт тавьж хэрэгжүүлэх шатандаа явж буй:

Эх үүсвэр	Бараа, ажил үйлчилгээний тоо	Төсөвт өртгийн дүн, сая төгрөг
Нийслэлийн төсөв	3	1 468,7
ОНХС	4	40,0
Улсын төсөв	1	2 050,0
БҮГД	8	3 558,7

Худалдан авах ажиллагааны шатандаа буюу гэрээ байгуулах зөвлөмж ирүүлээгүй, гэрээ байгуулаагүй улсын төсвийн 19,491.4 сая төгрөгийн өртөг бүхий 2, нийслэлийн төсвийн 2,530.1 сая төгрөгийн 14 бараа, ажил үйлчилгээнд захиалагчийн хяналт тавихаар хүлээгдэж байна.

3.7. Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн талаар

Байгууллагын 2019 оны санхүүжилт болох орон нутгийн төсвөөс **1,114,980.2 сая** төгрөг, жилийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх **449,869.0 сая** төгрөг, нийт **1,564,849.20 сая** төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас зардлын сар, улирлын хуваарийг Нийслэлийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээр батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 01-ний дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлэн хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Өнгөрсөн 2018 оны жилийн эцэст үүссэн 28 байгууллагын 88,7 сая төгрөгийн өр авлагаас 24 байгууллагын 54,9 сая төгрөгийн өр авлагыг барагдуулж, нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.

Мөн Аудитын байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу балансад тусгагдаагүй байсан 2 байгууллагын 10,5 сая төгрөгийн өр авлагыг балансад тусгасан.

Байгууллагын зардлыг төлөвлөсөн төсвөөс хэтрүүлэхгүй хэмнэж ажилласны үндсэн дээр байр ашиглалт, бараа үйлчилгээний бусад зардал, хангамжийн материал болон бусад зардлаас 36,745,287.58 төгрөгийг хэмнэсэн байна.

Эдийн засгийн үзүүлэлт	Төлөвлөгөө /2019.10 сарын байдлаар/	Гүйцэтгэл /2019.10 сарын байдлаар/	Хэмнэлт /2019.10 сарын байдлаар/
Төсвөөс урсгал санхүүжилт	945,597,600.00	945,597,600.00	0

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Үндсэн үйл ажиллагааны орлогоос	480,827,600.00	233,316,975.00	247,510,625
Үндсэн ба нэмэгдэл цалин	670,532,000.00	609,738,615.0	60,793,385
Ажилчдын тоо	65	65	65
Нэг хүнд ногдох дундаж цалин	1,031,587.60	927,551.00	
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	37,748,400.00	9,788,680.00	27,959,720.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,000,000.00	14,031,166.87	10,968,833.13
Хангамж бараа материалын зардал	39,750,000.0	38,234,727.34	1,515,272.66
Бараа үйлчилгээний зардал	15,617,000.0	9,728,462.0	5,888,538

- Байгууллагын 2018 оны хагас жилийн эцсийн тайлан балансыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хуулийн хугацаанд нь гаргаж “Нийслэл дэх Төрийн Аудит”-ын газраар хянан баталгаажуулж, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.
- Байгууллагын 2018 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ/ төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй гэсэн **“Аудитын гэрчилгээ”** дүгнэлт авсан.
- Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Баянхошуу дэд төвд баригдаж буй Бизнес инкубатор төв, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгын ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллах Ашиглалтын захиргаа байгуулах, төсвийн төслийг 229,984,556.60 төгрөгийн төсвийн саналыг Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.
- Хөрөнгө оруулалтын 12 аж ахуйн нэгжийн 97,816,475 төгрөгийн барьцааг чөлөөлж, 21 аж ахуй нэгжийн 121,209,422.33 төгрөгийн барьцааг шинээр бүртгэсэн.
- Хөрөнгө оруулалтын 5 захирамжаар 18 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж 4 026 788 476 төгрөгийн гэрээг хянаж санхүүжилтийг олгосон.
- Тайлант хугацаанд нийслэлийн 2019 оны төсөвт тусган батлагдсан 4 байгууллагын 1155,7 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарийн дагуу НӨАУГ-ын дансаар дамжуулан олгосон байна. Үүнээс: “Нийслэлийн Орон сууцны корпораци” ХК – 330,0 сая төгрөг, “Олон улсын худалдаа логистикийн төв” ХК – 275,0 сая төгрөг, “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК – 275,7 сая төгрөгийн санхүүжилтийг тухай бүр олгон, сар бүрийн 05-ны дотор төсвийн гүйцэтгэлийн мэдээг НЗДТГ-т хүргүүлж байна.
- Нийслэлийн Засаг даргын 2019.05.22-ны өдрийн А/493 дугаар захирамжаар “Улаанбаатар спорт менежмент” ХК-ийн дүрмийн сангийн 5,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хянаж олгосон.
- Урьд онуудын түрээсийн авлагаас 23 иргэн аж ахуй нэгжийн 71,521,900.00 төгрөгийг барагдуулсан. Аудитын албан шаардлагын дагуу “Харднис” ХХК-тай холбоотой түрээсийн 10,667,200.00 төгрөгийн авлагыг 1 дүгээр улирлын тайланд залруулан тайлагнаж авлагад тусган, түрээсийн төлбөрийн өрийг барагдуулсан.
- Нийслэлийн Хот тохижилтын газар 226,0 сая төгрөг, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас 5,0 сая төгрөгийн ногдол ашиг өрийг барагдуулж төсөвт төвлөрүүлсэн.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Төсөвт төвлөрүүлэх орлого төрөл	2019.12.30-ны байдлаар			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	(- илүү, + дутуу)
1	Түрээсийн орлого	1,800,000.0	2,072,326.3	115,1%	-272,326.3
2	Өмч хувьчлал	50,220,000.0	314,974.0	0,6%	49,905,026.0
3	Ногдол ашиг	650,000.0	994,097.6	145,2%	-294,097.6
4	Актлагдсан хөрөнгө борлуулсны болон автомашины дуудлага худалдааны орлого	160,000.0	160,420.8	100,3%	-420.8
Дүн		52,830,000.0	3,491,818.8	6.6%	

3.7.1 Төсвийн ил тод байдлын талаар:

Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу мэдээллийг цаг тухай бүр мэдээлэн ажиллаж байна. Үүнд:



3.7.2. Байгууллагын балансад бүртгэлтэй хөрөнгийн талаар:

№	Тогтоол, захирамжийн нэр	Хөрөнгийн нэр	Бүртгэлийн үнэ
Балансаас хассан барилга, байгууламж			
1.	НИТХТ-ийн 2019 оны 13 дугаар тогтоол, НЗД-ын 2019.02.26-ны А/130 дүгээр захирамж	ЧД-ийн “Нандин хүсэл” Өрхийн эмнэлэгийн хуучин барилга	44,034,120 төгрөг
2.	НИТХТ-ийн 2019 оны 16 дугаар тогтоол, НЗД-ын А/184 дүгээр захирамж	СБД-ийн 10 дугаар хорооны 1 барилга	79,228,531 төгрөг
3.	НӨХК-ийн 01 дүгээр тогтоол, НӨАУГ-ын А/137	ХУД-ийн Цагдаагийн түр саатуулах байр	23,712,000 төгрөг
Балансаас балансад шилжүүлсэн хөрөнгө			
1.	НИТХТ-ийн 13 дугаар тогтоол, НЗД-ийн А/130	БГД-ийн 2 дугаар хорооны “Эрхэм жаргалан” ӨЭМТ-ийн барилга	50,198,400 төгрөг
2.	НИТХТ-ийн 13 дугаар тогтоол, НЗД-ийн А/130	СХД-ийн “Анан” ӨЭМТ-ийн барилга	20,230,900 төгрөг

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

3.	НИТХТ-ийн 99 дүгээр тогтоол, НЗД-ийн А/707, НӨАУГ-ын А/257 дугаар тушаал	СХД-ийн 9 дүгээр сургуулийн байр	285,100,508 төгрөг
		6 барилга, байгууламж	502,504,459 төгрөг



ХУД-ийн Цагдаагийн түр саатуулах байр



ЧД-ийн “Нандин хүсэл” ӨЭМТ-ийн барилга



СХД-ийн 9 дүгээр сургуулийн байр



БГД-ийн 2 дугаар хорооний “Эрхэм жаргалан” ӨЭМТ-ийн барилга


3.7.3 Нийслэлийн өмчийн мэдээллийн сангийн баяжилтын талаар

“Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТӨБЗГ-аас БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага “КОЙКА”-тай хамтран боловсруулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-ийн программыг 5 дах жилдээ ашиглаж, мэдээллийг жил бүр шинэчлэн, сайжруулах ажлыг хийж байна.

Нийслэлийн өмчит 770 байгууллагын тайлан балансыг хүлээн авч нэгтгэн 2018 оны жилийн эцсийн балансаар нийт хөрөнгө 3,823,212.8 сая төгрөг үүнээс эргэлтийн бус хөрөнгө 3,219,405.8 сая, эргэлтийн хөрөнгө 603,807.1 сая төгрөг байна. /Элэгдэл тооцоогүй дүнгээр буюу бүртгэлийн анхны үнээр авч үзвэл нийслэлийн өмчийн эргэлтийн бус хөрөнгө 3.839.172,7 сая төгрөгт хүрчээ. /Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Үндэсний Статистикийн газарт 770 байгууллагын өмчийн бүртгэлийн дүн мэдээг ТӨ болон ТӨХ маягуудын дагуу тайлагнаж хүргүүлэв.

➤ 2018 онд

- ✓ Эргэлтийн бус хөрөнгө 3.219.405,8 сая төгрөг
- ✓ Эргэлтийн хөрөнгө 603,807,1 сая төгрөг
- ✓ Нийт 3,823,212.8 сая төгрөг



3.7.4. Түрээсийн гэрээ байгуулах, орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд:

Газрын даргын 2019.01.04-ний өдрийн А/01 дүгээр “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг түрээсийн гэрээний биелэлтийг дүгнэн, 1,034,130,44.0 төгрөгийн үнийн дүн бүхий 341 түрээсийн гэрээ байгуулав.

- ✓ Урт цагаан үйлчилгээний төв - 25
- ✓ Дам түрээс буюу “Өмч эзэмшлийн гэрээ”-гээр эзэмшдэг байгууллагуудын - 122 түрээсийн гэрээ
- ✓ Соёлын төв өргөөний - 35
- ✓ Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн - 35
- ✓ Ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрийн арга хэмжээний хүрээнд нийт 115 сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулав.

Нийслэлийн өмчийн барилга байгууламжид Түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хүрээнд:

Нийслэлийн өмчит 53 байгууллагуудад 2018 оны түрээсийн гэрээний биелэлтийг дүгнэж ирүүлэх тухай 1/10 тоот албан бичиг явуулан газрын даргын 2019.01.04-ны өдрийн А/01 тушаалаар томилогдсон ажлын хэсэг түрээсийн гэрээний дүгнэх хуудсыг үнэлсэн.

НИТХТ-ын 2018 оны 40-р тогтоолоор батлагдсан шинэчилсэн тарифаар 2019 онд нийт 1.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 374-н түрээсийн гэрээг байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан. Үүнд:

- Урт цагаан үйлчилгээний төвийн шууд түрээс 1-30
- Соёлын төв өргөөний шууд түрээс 1-36
- Өмчийг эзэмшигч байгууллагуудын дам түрээс 131
- Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨАТҮГ-ийн шууд 1-26
- “Үдийн цай” хөтөлбөрийн түрээс 115
- НӨАУГ-ын шууд түрээс 10
- Үүрэн телефоны Gmobile 9, Mobicom 11, Unitel 6 нийт 26

Газрын даргын 2019 оны А/358 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу НИТХТ-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам”-ын хэрэгжилтийн байдал, зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэх, түрээсэлж байгаа талбайн хэмжээ түрээсийн гэрээнд тусгасан талбайн хэмжээтэй тохирч буй эсэхийг шалгалт хийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Урт цагаан үйлчилгээний төвийн түрээсийн талаар

УЦҮТ-ийн нийт 31 иргэн, аж ахуйн нэгжтэй түрээсийн гэрээ байгуулан талбайн түрээс, ашиглалтын зардлыг тус тусад нь тооцон төвлөрүүлдэг байна. Үүнээс Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ашиглаж байгаа 985.6 мкв талбайгаас түрээсийн төлбөр авдаггүй ба зөвхөн ашиглалтын зардал тооцон, сард 5.07 сая төгрөг, жилд 60.8 сая төгрөг төвлөрүүлдэг. Иргэн, аж ахуйн нэгж нийт 6,351 мкв талбай эзэмшиж ашиглаж байгаагаас 5,329 мкв ашигтай, 1,022 мкв нийтийн эзэмшлийн талбай эзэлж байна. Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

ашиглаж байгаа 985.6 мкв-ийн хасч тооцвол 4,343 мкв ашигтай талбай, 1,022 мкв нийтийн эзэмшлийн талбай түрээслүүлэн, түрээсийн төлбөрт сард нийт 53.5 сая төгрөг буюу жилд 642.1 сая төгрөг төвлөрүүлэх тооцоо гарч байгаа боловч түрээсийн гэрээгүй, шүүхийн маргаантай зэрэг асуудлаас болж 561.1 сая төгрөг төвлөрөхөөр байна. Байрны ашиглалтын зардал 2017 онд 366.7 сая, 2018, 2019 онд 428.9 сая төгрөг болж өссөн. Шүүхийн маргаан болон бусад шалтгаан, ашиглалтын зардал жил бүр нэмэгдсэнээр нийслэлийн төсөвт төвлөрөх дүн буурсан байна. ҮЦҮТ-ийн 6-р корпусын 1-р давхарт үйл ажиллагаа явуулдаг “Shirt shop” дэлгүүр, “Нарлаг тал” ХХК-ийн түрээсийн гэрээ баталгаажаагүй, “Монголын Үйлдвэрлэл эрхлэгчдийн хоршоо”, иргэн Ё.Мэндбаярын 12 дугаар корпусын 1 дүгээр давхарт үйл ажиллагаа явуулж буй хэсэг, иргэн Болдтой түрээсийн гэрээ огт байгуулаагүй байна. Түрээсийн гэрээ байгуулсан ихэнх компаниуд уг объектод байрладаггүй, гэрээнд заасан зориулалтын дагуу үйл ажиллагаа эрхэлдэггүй, байр талбайг зөвшөөрөлгүй бусдад дамжуулан түрээсэлсэн, ажлын байрны дүгнэлт, зөвшөөрөлгүй 8 нэрийн барааны дэлгүүр, эмийн сан ажиллуулсан, алт, үнэт эдлэл худалдан авах худалдаалах, алт хайлуулах үйлдвэрлэл явуулсан, агааржуулалтын системийг дур мэдэн өөрчилсөн гэх мэт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байна. Иймд мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй, галын аюул үүсэх, газар хөдлөх зэрэг гамшиг, осол тохиолдоход нурах аюултай байр, талбайг бусдад түрээслүүлэх боломжгүй нөхцөл бүрдсэн тул холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтарсан шалгалтыг хийж дүгнэлтийн дагуу цаашид авах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.



Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-ийн түрээсийн талаар

“Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ нь иргэдэд зориулан 5-10 дугаар саруудад худалдаа, үйлчилгээ явуулдаг ба шалгалтаар түрээсийн гэрээ шалгах, төлбөр тооцоо нийлэх, түрээсийн талбай болон сунган өргөтгөл хийсэн ТҮЦ-ийн талбайн хэмжилт хийх зэрэг ажлуудыг хийлээ. Тус үйлдвэрийн газар нь 2014-2015 онд 28, 2019 онд 4 ТҮЦ байршуулж түрээсийн гэрээ байгуулж ажилладаг ба 2019 онд 42 иргэн, аж ахуй нэгжтэй 3 талт гэрээ байгуулан ажиллаж нийслэлийн төсөвт 65,498,700.0 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Шалгалтаар хүрээлэнгийн гадаа задгай талбайд үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан 62 иргэн аж ахуйн нэгжтэй сарын 150,000 төгрөгөөр 5 сар үйл ажиллагаа явуулах 2 талт гэрээг байгуулсан байсныг түрээсийн гэрээний 60%-ийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үүрэг өгч цаашид НӨАУГ-аар батлуулан ажиллах талаар зөвлөмж өгч ажилласан. Мөн ихэнх ТҮЦ нь талбайгаа сунгаж павильон барьсан зөрчилтэй байсан ба талбайг дахин хэмжиж, талбайн зөрөөг тооцон, түрээсийн гэрээг шинэчилснээр талбайн зөрөөнөөс төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.



3.8. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаар

3.8.1 Хүний нөөцийн хөтөлбөрийн талаар хийсэн ажлууд:

Төрийн албаны тухай хуулийн 54, 55 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг дотоод ажил хариуцсан мэргэжилтэнтэй хамтран боловсруулж, газрын даргаар батлууллаа. Мөн Төсвийн шууд захирагчаар батлуулах 4 нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, нэгжийн дарга нараар батлуулах 37 төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, газрын даргатай байгуулах 27 төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг хагас, бүтэн жилээр үнэлэх, дүгнэх явцад хяналт тавин ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай” 02 дугаар тогтоол, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг батлах тухай” 03 дугаар тогтоолуудыг баримтлан байгууллагын 37 төрийн захиргааны ажлын байрны албан

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

тушаалын тодорхойлолтыг боловсруулж, дагалдах материалын хамт Төрийн албаны зөвлөлд хянуулахаар 2 удаа хүргүүлэв.

Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд хамаарах 19 ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Газрын даргын 2019.07.18-ны өдрийн А/258 дугаар тушаалаар батлуулан, төрийн үйлчилгээний албан хаагчдад танилцуулан гарын үсгээр баталгаажууллаа.

Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн систем”-д албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээллийг сар тутам тогтмол шинэчлэн оруулсан.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу нийт албан хаагчдын төрийн албан хаагчийн анкет болон шаардлагатай бусад материалыг шинэчлэн бүрдүүллээ.

Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу 7 төрийн жинхэнэ албан хаагчид албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг Нийслэлийн Төрийн Албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүллээ.

Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны 8 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгосон.

Төрийн үйлчилгээний 12 албан хаагчид ур чадварын нэмэгдлийг тус тус шинээр олгосон.

	Тушаалын нэр	Тоо	Биелэлт
1	Ажлаас чөлөөлөх тухай	8	100%
2	Ажилд томилох тухай	22	100%
3	Ажлаас халах тухай	2	100%
4	Зардал гаргах тухай - /11 хүнд/	3	100%
5	Цалин хөлстэй холбоотой	6	100%
6	Буцалтгүй тусламж олгох тухай-/1 хүнд/	1	100%
7	Сахилгын шийтгэл ногдуулах тухай-/2 хүнд/	1	100%
8	Чөлөө олгох тухай	5	100%
9	Тэтгэмж олгох тухай- /6 хүнд/ 1,700,000 төгрөг	6	100%
10	Ээлжийн амралт олгох тухай	2	100%
11	Шилжүүлэн ажиллуулах тухай	11	100%
12	Бүтэцтэй холбоотой	2	100%
13	Бүтцийн өөрчлөлтөөр тэтгэмж олгох тухай - /5 хүнд/	5	100%
14	Бусад	11	100%
	Нийт	87	100%

Ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, эмнэлэгийн чөлөөтэй - 13 /листээр/, захиргааны чөлөөтэй – 39, газрын даргын тушаалаар-3 албан хаагчийн чөлөө олгох бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж, сар бүрийн эцэст албан хаагчдын хоцролт, таслалтын мэдээг минутаар гарган орлогч дарга, хэлтсийн дарга нарт танилцуулж байна.


3.8.2. “НӨАУГ-ын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2019 оны төлөвлөгөө”-ний талаар

- Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу ар гэрт нь гачигдал тохиолдсон 6 ажилтан, албан хаагчид 1,700,000 төгрөгийн тэтгэмжийг олгосон байна. Мөн ажлаас чөлөөлөгдсөн 5 албан хаагчид тэтгэмж олгосон.

- Байгууллагын албан хаагчдаас галлагаатай гэр, байшинд амьдардаг 14 албан хаагчийн өвөлжилтийн бэлтгэлд зориулан сайжруулсан шахмал түлш худалдан авахад дэмжлэг болгон 3,500,000 төгрөгний тусламж үзүүлсэн.
- Байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан баримтыг төрийн архивын байнгын хадгалалтад шилжүүлэх болсонтой холбогдуулан нөхөн бүрдүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн 5 албан хаагчид илүү цагийн урамшуулал, “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ээр идэвхтэй ажиллаж, амжилттай дүн үзүүлсэн 24 албан хаагчид урамшуулалт цалин олгосон.
- Тайлант хугацаанд 1 албан хаагчийг Төр засгийн одон медальд, ТӨБЗГ-ын шагналд 1 албан хаагч, Яамдын шагналд 4 албан хаагч, НИТХ-ын шагналд 6 албан хаагчийн, НЗД-ын шагналд 5 албан хаагчийн тодорхойлон шагнасан.

3.8.3. Сургалт семинар, нийгмийн баталгаа

Албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зорилгоор 2019 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, “Мэдээллийн цаг”-ийн хуваарийг баталсан.



Мөн зорилтот богино хугацааны сургалт, НЗДТГ, НАГ, ГХЯ, АТГ, ТӨБЗГ зэрэг дээд шатны байгууллагуудаас зохион байгуулсан сургалтад 16 албан хаагчийг хамруулсан байна.

НЗДТГ, НТАЗСЗ, холбогдох бусад байгууллагуудад дараах мэдээ, судалгаа мэдээллүүдийг хүргүүлсэн.



Харьяа, дээд байгууллагаас зохион байгуулагдсан сургалтууд:

- Төрийн архивын нөхөн бүрдүүлэлт хийх, байгууллагыг нэгдсэн арга зүйгээр хангах сургалтанд 2019.01.25-ны өдөр архив, бичиг хэгийн ажилтан Т.Азжаргал
- Гадаад хэргийн яамнаас 2019.03.19-ний өдөр зохион байгуулсан Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах сургалтад 2 албан хаагч
- XXI зууны төрийн албаны менежер сургалтад 2019.03.22-ны өдөр газрын дарга
- ХУД-ын ИТХ-ын хуралдааны танхимд 2019.03.29-ний өдөр зохион байгуулсан “Эрүүл ажлын байр – Эрүүл амьдарлын хэв маяг” сэдэвт сургалтад бичиг хэргийн ажилтан Э.Дөлгөөн
- Удирдлагын академи дээр зохион байгуулагдсан “Төрийн албаны шинэчлэлийн бодлогын үзэл баримтлал” сэдэвт сургалт,
- АТГ, НЗДТГ-аас зохион байгуулсан ХАСХОМ-ийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалт
- НЗДТГ-аас зохион байгуулсан “Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт”-ийн талаарх 2 өдрийн сургалт
- Онцгой байдлын газраас зохион байгуулсан “Гамшгаас хамгаалах” сургалт
- Нийслэлийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтад аюулгүй талбайд түр цуглах дадлага сургуулилтад оролцсон
- Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх сургалт 2019.06.18-ны өдөр
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар сургалтад 2019.06.19-ны өдөр холбогдох болон ажил хариуцсан албан хаагчид оролцсон.
- Худалдан авах ажиллагааны АЗ сертификатай сургалтанд 4 албан хаагчийг сургасан.
- “Эрүүл ажлын байр” удирдамжийн дагуу хэрэгжүүлэх ажлын дэд хөтөлбөрийн дагуу сургалт, тэмцээнүүдэд оролцсон.
- Байгууллагын ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зохион байгуулалтад оролцсон.

- НЗДТГ-аас 2019.10.23-ны өдөр “Бодлогын баримт бичигт хийсэн дүн шинжилгээ” сургалтад хамрагдлаа.
- НЗДТГ-аас Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх тухай сургалтад 2019.11.14-ний өдөр Нийслэлийн иргэний танхимд зохион байгуулсан сургалтад оролцлоо.

3.8.4. Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах талаар:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст байгууллагын төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг хүргүүлж, хуулийн үйлчлэлд хамаарах ТЗ-6-аас дээш ангиллын 12 албан хаагчдаас 2018 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг, 1 удаагийн тушаалын дагуу ажлын хэсэгт орсон 3 гишүүнээс “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг авч, дэвшүүлэн томилогдсон 8 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулж холбогдох байгууллагаар хянуулан томиллоо.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ”БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ”

4.1. Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай болгох стратегийн зорилтын хүрээнд

Нийслэлийн Өмчийн харилцааны талаарх мэдээ мэдээллийг түгээх, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээ мэдээлэл хүргэх, үйл ажиллагааг зохицуулах зорилгын хүрээнд МУ-ын хууль Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг байгууллагын цахим хуудасны үйл ажиллагаанд мөрдлөг болгон үндсэн үйл ажиллагаатай холбоотой болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулагдаж буй ажлуудын талаарх 69 мэдээллийг цахим хуудаснаа байршуулан ажиллалаа. Үүнээс:

- ✓ Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цайны газрын түрээслэгчийг сонгон шалгаруулагчийн урилга -37
- ✓ Дуудлага худалдааны зар -1
- ✓ Тендерийн урилга -1
- ✓ Журмын төсөлд санал авах -1
- ✓ Журам гэрээний төсөл батлуулсан талаар -1
- ✓ Эрүүл ажлын байр аяны хүрээнд -20
- ✓ Бусад -8

Үйл ажиллагааны ил тод байдлын хүрээнд:

- ✓ Байгууллагын дүрэм
- ✓ Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм
- ✓ Хөдөлмөрийн дотоод журам

- ✓ Газрын даргын тушаалаар батлагдсан дотооддоо дагаж мөрдөж буй дүрэм журмууд
- ✓ Үйл ажиллагааны тайлан / улирал бүрээр /
- ✓ Төрийн үйлчилгээ өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний мэдээлэл
- ✓ Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ / улирал бүрээр /
- ✓ Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ /улирал бүрээр/,
- ✓ Албан хаагчидтай холбогдох утасны жагсаалт албан имэйл хаягийг тогтмол шинэчилдэг
- ✓ Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарсан газрын даргын 600 тушаал
- ✓ Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарсан НИТХТ-ийн 34 тогтоол

Хүний нөөцийн ил тод байдлын хүрээнд:

- ✓ 2019 оны хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
- ✓ Ажлын байрны сул орон тооны зар /3 удаа/
- ✓ Газрын даргын гадаад томилолтын талаарх мэдээлэл
- ✓ Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолын хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”
- ✓ 2019 онд шинээр ажилд томилогдсон албан хаагчдын мэдээлэл

Төсөв санхүүгийн ил тод байдлын хүрээнд:

- ✓ 2019 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ /сар бүрээр/
- ✓ Санхүүгийн тайлан /2019 оны эхний хагас жилийн байдлаар/
- ✓ Аудитын дүгнэлт

4.2. Хууль шүүхийн байгууллагад төлөөлөх ажлын талаар

“Анома” ХХК-ийн нэхэмжлэлтэй дээд шүүхийн хурал 2019.05.14-ний өдөр хуралдаж, Иргэний хэргийн анхан шатны шүүхэд дахин хянуулахаар буцсан. “Эрдэнэсуварга” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Нийслэлийн Засаг даргад холбогдох маргаан бүхий захиргааны хэргийг 2019.02.19-ны өдрийн шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.14-т заасны дагуу нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

Анхан шатны шүүхэд хянагдаж байгаа хэргийн мэдээ

	Нэхэмжлэгч	Хариуцагч	Гуравдагч этгээд	Нэхэмжлэлийн утга	Тайлбар
1	Н.Баасанжав” Хайрхан - Уул Өргөө ХХК”	НӨАУГ	-	Дэнчин 24,6 сая төгрөг гаргуулах	УДШ-д буцсан.Хурал зарлаагүй байна.
2	Анома ХХК	НИТХ, НӨАУГ	-	3,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг гаргуулах	Улсын дээд шүүхээс буцсан.Хурал зарлаагүй байна. Дахин шинжээч томилсон.
3	Хар дун ХХК	НЗД, НИТХ	-	1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын асуудал.	Захиргааны шүүхэд хянагдаж байна. Нотлох баримт гаргуулахаар хэргийг түдгэлзүүлсэн.
4	Гангар инвест ХХК	НИТХ, НЗД	-	Гэр хорооллын 3,3 тэрбум төгрөгийн дахин төлөвлөлтийн төслийн асуудлаар НИТХ-ын	Зах.шүүх 2019.09.25-нд түдгэлзүүлсэн /шинжээчийн дүгнэлт гаргуулахаар/

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

				147-р тогтоолыг хууль бусад тооцуулах	
5	Буяннэмэх Интер ХХК	НӨАУГ	-	332.0 сая төгрөгийн өмчийн асуудал	Зах.шүүхэд хянагдаж байна. 2019.11.20-ны өдөр шинжээчийн дүгнэлт гаргуулахаар түдгэлзүүлсэн.
6	Эрдмийн их сургууль	ТӨХ, НЗО, НИТХ	-	СБД-ийн ТК-415 халаалтын цогц ТӨХ бүртгэлийн тухай	Зах.шүүхэд хянагдаж байгаа /Шүүгч Оюунаа/
7	Я.Эрдэнэчи мэг	НЗД /НӨАУГ/	-	СБД-ийн 11-р хороонд байрлах газар	Зах. шүүхэд хянагдаж байгаа / Шүүгч Одмаа/
8	ЗТХЯам, НӨАУГ, НТҮГ	Автобус нэгдэл ХХК	-	10 автобус, төлбөр 649.0 мян.төг	СХД-ийн шүүхэд хянагдаж байна.
9	ЗТХЯам, НӨАУГ, НТҮГ	Мяралзаа ХХК	-	8 автобус, төлбөр 584.5 мян.төг	БЗД-ийн шүүхэд хянагдаж байна.
10	ЗТХЯам, НӨАУГ, НТҮГ	Автобус-1 НӨҮГ	-	120 автобус, төлбөр 6,847.3 мян.төг	ХУД-ийн шүүхэд хянагдаж байна.
11	ЗТХЯам, НӨАУГ, НТҮГ	Автобус-3 НӨҮГ	-	80 автобус, төлбөр 6,076.1 мян.төг	СБД-ийн шүүхэд хянагдаж байна.
12	ЗТХЯам, НӨАУГ, НТҮГ	Цахилгаан тээвэр НӨҮГ	-	50 автобус, төлбөр 3,531.3 мян.төг	ХУД-ийн шүүхэд хянагдаж байна.
13	ЗТХЯам, НӨАУГ, НТҮГ	Тэнүүн дэлгэр ХХК	-	14 автобус, төлбөр 1,060.4 мян. төг	
14	ЗТХЯам, НӨАУГ, НТҮГ	Атибус ХХК	-	8 автобус, үнэ 468,261 төг	
15	Б.Ичинхорлоо	НЗД	-	НЗД-ын 2019.07.24-ны өдрийн Б/123 тоот захирамж болгуулах	/Ажлаас халагдсан тухай/ Захиргааны хэргийн шүүхэд хянагдаж байна.
16	Цэгц гэрэлт ХХК	НӨАУГ	-	Үдийн цай хөтөлбөр	Захиргааны хэргийн шүүхэд хянагдаж байна.
17	НГЗБА	НӨАУГ	-	Газрын төлбөр 57.6 сая төгрөг	Захиргааны хэргийн шүүхэд хянагдаж байна.

Давж заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа хэргийн мэдээ

№	Нэхэмжлэгч	Хариуцагч	Гуравдагч этгээд	Нэхэмжлэлийн утга	Тайлбар
1	Улаанбаатар паласе, Улаанбаатар синема	УБЕГ, НИТХ, НӨАУГ	-	Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний асуудал	2019.10.03-ны өдрийн ЗХАШШ-ийн 0757 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийг хэрэгсэгүй болгосон.
2	ЗТХЯам, НӨАУГ, НТҮГ	Сутайн буянт ХХК	-	30 автобус, төлбөр 2.0 тэрбум төг	Анхан шатны шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон.
3	ЗТХЯам, НӨАУГ, НТҮГ	Тэнүүн огоо ХХК	-	50 автобус, төлбөр 3,862.4 мян.төг	БГД-ийн Анхан шатны шүүх нэхэмжлэлийг хангасан.
4	ЗТХЯам, НӨАУГ, НТҮГ	Эрдэм транс ХХК	-	30 автобус, төлбөр 2,168.1 мян.төг	БГД-ийн Анхан шатны шүүх нэхэмжлэлийг хангасан.

Нийт 30 тэрбум төгрөгийн холбогдолтой хэрэг маргаан шийдвэрлэгдсэн байна.

**ТАВДУГААР БҮЛЭГ.
“БУСАД МЭДЭЭЛЭЛ”**


5.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар

5.1.1. Ирсэн бичгийн бүртгэл, хяналтын ажлын талаар:

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын EDOC программд 2019.12.30-ны өдрийн байдлаар нийт 4083 албан бичиг ирж бүртгэгдсэний дагуу хариу өгч хугацаанд нь шийдвэрлэсэн 3763 албан бичиг, судлагдаж байгаа 101 албан бичиг, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 221 албан бичиг байна. Албан бичгийн шийдвэрлэлт 94.69%-тай байна.


№	Хэлтэс	Шийдвэрлэлт			Нийт	Шийдвэрлэлтийн хувь
		Шийдвэрлэгдсэн	Судлагдаж байгаа	Хугацаа хэтэрсэн		
1	ЗСХ	735	2	5	742	97.2%
2	ӨБХХ	1099	43	99	1241	94.68%
3	ӨТМХ	1107	51	92	1250	94.93%
4	ӨМХАХ	804	5	24	833	94.91%
5	УЦҮТ	16	0	1	17	80%
	Нийт	3761	101	221	4083	94.69%

Ирсэн албан бичгийг графикаар үзүүлбэл:




НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Албан бичиг шийдвэрлэлтийг өмнөх онуудтай харьцуулбал:



/Албан хаагчид ирсэн бичгийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн/


Албан бичиг шийдвэрлэлтийг улирал тус бүрээр харьцуулбал:



5.1.2. Явуулсан бичгийн шийдвэрлэлтийн байдал

Жилийн эцсийн байдлаар 1945 албан бичигт дугаарлан EDoc программаар тухайн байгууллага руу шилжүүлж, албан бичгийг шуудангийн салбарт хүлээлгэн өгсөн. Явуулах албан бичгийг хүлээн авч албан бичгийн стандарт, хавсралт, явуулах газрын хаягыг, бүрэн зөв эсэхийг шалган, тамга, тэмдэг дарах, бүртгэж дугаарлах, дугтуйлах, хаяглах, шуудангийн салбарт хүлээлгэн өгөх зэрэг ажлуудыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэсэн.

Явсан бичгийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:



➤ *Албан хэрэг хөтлөлтийн стандарт шаардлагыг хангуулах ажлын талаар:*

Нийт албан хаагчдад 14 хоног тутам шийдвэрлэх хугацаа дөхсөн болон хугацаа хэтэрсэн албан бичгийн жагсаалтыг гарган, танилцуулж, гарын үсгээр баталгаажуулан хугацаандаа шийдвэрлэхийг мэдэгдэн ажилласан.

Архивын Ерөнхий газрын 2016 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан “Хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалах журам”-ын “Хэвлэмэл хуудас зарцуулсан тухай бүртгэл” хийх зааврын дагуу бүртгэл дэвтэр хөтлөн ажиллаж байна. Нийт 2016-2019 оны 35600ш хэвлэмэл хуудас захиалснаас байгууллагын нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан хуучин нэрээр хэвлэгдсэн хэвлэмэл хуудсыг НӨАУГ-ын даргын 2019 оны А/292 тушаал “Хэвлэмэл хуудас хүчингүй болгох тухай”-аар 6630ш хэвлэмэл хуудсыг хүчингүй болгосон.

2019 онд Албан байгууллагын хэрэгцээнд 2019.04.01-ний өдөр хэвлэмэл хуудас А4-2000ш, А5-2000ш, тушаал-2000ш, албан даалгаврын хэвлэмэл хуудас-100ш мөн 2019.08.28-ны өдөр хэвлэмэл хуудас А5-1500ш А4-1500ш тушаал-500ш тус тус ЕDoc программаар захиалан авсан.

Байгууллагын хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг сар, улирал, жилээр гаргаж байгууллагын удирдлагад танилцуулсан.

5.1.3. Архивын ажлын талаар

Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн архивын баримт материал, хадгаламжийн нэгжүүдийн эмх цэгцийг ханган ажиллах ажлын хүрээнд архивын баримтыг ирүүлэх тухай 2019.01.24-ний өдрийн газрын даргын 01 дүгээр албан даалгавраар хуваарь батлуулан, 2019.01.23 – 2019.02.13-ны өдрийн хооронд албан хаагчдаас архивын хадгаламжийн нэгжүүдийг архивт хүлээн авсан.



✓ 70 жил хадгалах - 9, Байнга хадгалах - 138, Түр хадгалах - 68 баримт

№	Баримтын төрөл	Баримтын хязгаар	Баримтын тоо	Тайлбар
1	Байнга хадгалах хадгаламжийн нэгж	2004- 2010	1188 ХН	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой баримтууд

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

2	Түр хадгалах хадгаламжийн нэгж	1999 – 2014	1401 ХН	Ирсэн, явсан бичиг, харилцахын баримт
3	70 жил хадгалах хадгаламжийн нэгж	1991-2018	30 ХН	Газрын даргын “Б” тушаал, санхүүгийн баримт /нийгмийн даатгал/
4	Нийт	1991-2018	2619 ХН	Хадгаламжийн нэгж

Мөн 2019.06.20-ны өдрийн байдлаар Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний 148 ширхэг баримтуудыг стандарт, журмын дагуу бүртгэл хөтлөн хүлээн авсан.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019.05.15-ны өдрийн А/117 дугаар тушаалаар “Байгууллагын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг шинэчлэн байгуулсан

5.1.4. Газрын даргын тушаалын биелэлтийн талаар:

Тайлант хугацаанд газрын даргын 2 албан даалгавар, 793 тушаал гарснаас “А” буюу хөрөнгө бүртгэн авах, балансаас балансад шилжүүлэх, данснаас дансанд шилжүүлэх, данснаас хасах зэрэг үндсэн чиг үүргийн дагуу 705 тушаал, “Б” буюу хүний нөөцийн чиглэлээр 88 тушаал гаргасан. Хэрэгжилт 100%-ийн биелэлттэй байна.

А-тушаал

№	Тушаалын нэр	Тоо	Биелэлт
1	Эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай	321	100%
2	Эргэлтийн бус хөрөнгө бүртгэх тухай	194	100%
3	Ажлын хэсэг байгуулах тухай	79	100%
4	Эргэлтийн бус хөрөнгө данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай	76	100%
5	Загвар батлах тухай	2	100%
6	Зардал гаргах, ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай	13	100%
7	Хариуцлагатай жижүүр, эргүүл томилон ажиллуулах тухай	1	100%
8	Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай	1	100%
9	Хоолны зардал шинэчлэн тогтоох тухай	0	100%
10	Бусад	18	100%
	Нийт	705	100%

Б-тушаал

№	Тушаалын нэр	Тоо	Биелэлт
1	Ажилд шинээр томилох тухай	25	100%
2	Ажлаас чөлөөлөх тухай	16	100%
3	Цалинг шинэчлэн тогтоох тухай	2	100%
4	Тэтгэмж, тусламж олгох тухай	9	100%
5	Зардал гаргах тухай	13	100%
6	Сахилгын шийтгэл ногдуулах тухай	1	100%
7	Чөлөө олгох тухай	8	100%
8	Ээлжийн амралтын хуваарь батлах тухай	2	100%
9	Албан хаагчийг шилжүүлэн ажлуулах тухай	12	100%
	Нийт	88	100%

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Байгууллагын хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг сар, улирал, жилээр гаргаж байгууллагын удирдлагад танилцуулан ажиллаж байна.

5.2. Иргэдийн өргөдөл, санал гомдол шийдвэрлэлтийн талаар:

ERP программ, Засгийн газрын /11-11/, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын /call center/-с ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авах, танилцуулах, биелэлтийг тооцож мэдээлэх ажлыг явуулж байна. Ирсэн өргөдлийг тухай бүр газрын даргаар цохуулж, хэлтэс албадад шилжүүлэх, шийдвэрлэлтэд хяналт тавих, тайлан мэдээг бэлтгэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт 2019.12.25-ны өдрийн байдлаар нийт 76 өргөдөл, гомдол ирснийг 100% шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног 16 цаг 19 минут байна. Судлагдаж байгаа өргөдөл гомдол байгууллагын хэмжээнд байхгүй болно.

2018 оны мөн үеийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаатай харьцуулбал 8 хоногоор нэмэгдсэн байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал:

№	Хэлтэс	Шийдвэрлэлт			Нийт	Шийдвэрлэлтийн хувь
		Шийдвэрлэгдсэн	Судлагдаж байгаа	Хугацаа хэтэрсэн		
1	Захиргаа санхүүгийн хэлтэс	30	-	1	30	100%
2	Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс	6	-	-	6	100%
3	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс	10	-	1	10	100%
	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтэс	30	-	-	30	100%
	Нийт	76	-	2	76	100%

Хүсэлт


- Архивын лавлагаа мэдээлэл хүссэн тухай 8
- Түрээсийн төлбөртэй холбоотой 12
- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон, ил задгай, худалдаа, үйлчилгээний тухай 6
- Нийслэлийн өмчийн худгийн ашиглалтын талаар тодруулга хүссэн, цэвэр, бохир усны шуга сүлжээний засвар, үйлчилгээний тухай 3
- Орон сууц хүссэн тухай 5
- Дуудлага худалдааны дэнчин буцаан авах тухай 6
- Ажилд орох хүсэлт гаргах тухай 3
- Ажлаас чөлөөлөгдөх тухай 2
- Цалинтай чөлөө хүссэн тухай 2
- Хүүхэд асрах чөлөөтэй холбогдох хүсэлт 2
- Бусад 25

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР


Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулбал:



Хариу өгсөн хэлбэр		
Программ+мессэж	Программ+ мессеж+утсаар	Программ+ мессеж+албан бичиг
12	39	25
Өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал		
Иргэний талд шийдвэрлэсэн	Боломжгүй тухай хариу өгсөн	Бусад
32	7	37



ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХУГАЦААГ 2019 ОНЫ САР БҮРЭЭР ХАРЬЦУУЛБАЛ:



Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хугацааг хэлтэс бүрээр харуулбал:

- ЗСХ 29, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 18 минут 59 минут
- ӨБХХ 6, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 14 хоног 14 цаг 29 минут
- ӨТМХ 9, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 15 хоног 10 цаг 32 минут
- ӨМХАХ 30, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 11 хоног 4 цаг 44 минут.

5.3. Засгийн Газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын дагуу хийж хэрэгжүүлсэн ажил

5.3.1. Сайжруулсан түлшийг хадгалах, нөөцлөх зориулалтаар бага дүнд оврын агуулахуудыг барьж байгуулах

Засгийн Газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын дагуу сайжруулсан түлшийг хадгалах, нөөцлөх зориулалтаар бага дүнд оврын агуулахуудыг барьж байгуулах ажлын хүрээнд эзэмших, өмчлөх эрх бүхий газраа нийслэлийн газрын санд шилжүүлэхээр хүсэлт гаргасан иргэдийн газар эзэмших, өмчлөх эрх дуусгавар болсон 107 байршилд буй газруудыг Нийслэлийн Засаг даргын 2019.04.11-ний өдрийн “Газар эзэмших эрх олгох тухай” А/287 дугаар захирамжаар нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газарт газар эзэмших эрх олгосон байна.

Дээрх 107 байршилд буй газруудыг хүлээн авах Ажлын хэсгийг НӨАУГ-ын даргын 2019 оны А/78 дугаар тушаалаар томилон, сайжруулсан түлшийг хадгалах, нөөцлөх, худалдан борлуулах зориулалтаар Сонгинохайрхан дүүрэгт 59, Сүхбаатар дүүрэгт 18, Чингэлтэй дүүрэгт 16, Баянзүрх дүүрэгт 14 байршил нийт 4 дүүргийн 107 байршилд байрлуулах ажлыг зохион байгуулсан.

“Таван толгой түлш” ХХК-ны үйлдвэрлэж байгаа сайжруулсан шахмал түлшийг “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар”-ын эзэмшлийн 107 байршлаар дамжуулж нөөцлөлт хийж борлуулах зорилгоор 2019.05.23-ны өдөр Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга, “Таван толгой түлш” ХХК-ний захирал нар нь № ТТТ2019 дугаартай “Хамтран ажиллах” гэрээг байгуулсан. Гэрээний дагуу 4 дүүргийн 107 байршил дахь газруудыг “Таван толгой түлш” ХХК-д хүлээлгэн өгөх ажлыг 2019.06.05-07-ны өдрүүдэд зохион байгуулсан.

5.3.2. Сайжруулсан түлшийг хороодын борлуулалтын цэгээс нийлүүлэлт, түгээлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан тухай

МУ-ын ЗГ-ын “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хүрээнд байгууллагын удирдах ажилтнууд ЧД-ийн 9,10 дугаар хороонд ажилласан. Мөн тус хороодод сайжруулсан түлш борлуулж буй 4 иргэнээс долоо хоног бүрийн даваа, пүрэв гаригуудад явцын мэдээг авч НЗДТГ, ЧДЗДТГ-т албан бичгээр болон цахим хаягаар хүргүүлсэн. Нийт 22 удаагийн явцын мэдээгээр 767 тонн /өссөн дүнгээр/ сайжруулсан түлш иргэдэд борлуулж, нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажилд дэмжлэг үзүүлж байна.

“Нийслэл дүүргүүдийн Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаанд 24 цагаар хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын удирдамж”-ийн

дагуу 2019.12.27-ны өдрийн 09:00 цагаас 2019.12.28-ны өдрийн 09:00 цаг хүртэл Газрын дарга Ш.Үнэнбатаар ахлуулсан хариуцлагатай жишүүрийн баг нэр бүхий 8 албан хаагч, 3 жолооч, нийт 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр нийслэлийн 6 дүүрэгт сайжруулсан шахмал түлш борлуулах цэгүүдийн ирүүлж буй мэдээнд хяналт тавин нэгтгэн, 24 цагаар хариуцлагатай зохицуулагчийн үүрэг гүйцэтгэв.



5.3.3. Гэр хорооллын айл өрхүүдийг түлшний галлагаанаас үүдэлтэй угаарын хийн хордолтоос сэргийлэх, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг, иргэдэд хүргэх арга хэмжээг богино хугацаанд зохион байгуулах

Зөвлөмж, сэрэмжлүүлэг мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд тогтмол хүргэн ажиллаж байна. Зөвлөмжийг газрын пэйж хуудас олон дагалдагчидтай 100 гаруй группээр нийтэд хүргэж байна.

Цахим сайт болох

- <http://unuudur.mn>
- [Olloo.mn](http://oloo.mn)
- <https://news.zindaa.mn>
- <http://www.report.mn>
- <http://ardchilal.mn>
- <http://chuhai.mn> зэрэг сайтуудад мэдээллийг байршуулаад байна.

Байгууллагын удирдах ажилтнууд 2019.10.08-2019.10.10-ны өдрүүдэд, 2019.11.03-ны өдөр ЧД-ийн Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, БНД-ийн Онцгой байдлын хэлтэс болон Таван толгой ХХК-тай хамтран ЧД-ийн 9,10 дугаар хорооны нийт 3321 өрхөд тараах материал зөвлөмжийг хүргэж ажилласан.

5.4. Архивын нөхөн бүрдүүлэлт хийхтэй холбоотойгоор Нийслэлийн Архивын газартай байгуулсан гэрээний хэрэгжилт

Архивын нөхөн бүрдүүлэлт хийхтэй холбоотойгоор Нийслэлийн Архивын газартай нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хамтран ажиллах 2019-26 дугаартай гэрээг 2019.02.15-ны өдөр байгуулан А/27 дугаар тушаалаар архивын нөхөн бүрдүүлэлт хийх ажлын хэсэг байгуулагдан, төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Нийслэлийн Архивын газартай байгуулсан “Нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хамтран ажиллах тухай гэрээний дагуу хадгаламжийн нэгжүүдэд иж бүрэн тооллого, нягтлан шалгалтыг хийсэн.

Дээрх эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлын үр дүнд данс бүртгэлийг байгууллагын ББНШК-ын 2019.08.28-ны өдрийн 04 дугаар хурлаар хэлэлцүүлэн баталж, 2018.08.30-ны өдөр нийслэлийн ББНАЗК-ын хурлаар амжилттай хэлэлцүүлсэн. Комиссын хурлын тэмдэглэлийн дагуу Нийслэлийн Архивын газарт 1997-2014 оны 914 ширхэг баримт, 2004-2010 оны 1188 баримтыг хүлээлгэн өгөхөөр шийдэрлэсэн.

Д/д	Баримтын төрөл	Он цагийн хязгаар	Баримтын тоо
1	Байнга хадгалах хадгаламжийн нэгж	1997-2018	3243
2	70 жил хадгалах	1991-2018	78
3	Түр хадгалах хадгаламжийн бүртгэл	2004-2018	1837
4	Устгах хэргийн	1999-2008	367
5	Байгууллага дээр байнга хадгалах	2011-2018	16
6	Газрын албанд шилжүүлэх	2011-2015	46
Нийт-5587			

5.5. Хяналт шалгалтын ажлын талаар

Эрүүгийн цагдаагийн албанаас байгуулсан “АСЕМ”-ын хүрээнд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон бүтээн байгуулалтын нийт 34,067,200,000 төгрөгийн хөрөнгийг газар дээр нь очиж шалгах болон материалтай танилцах ажлын хэсэгт 2018.12.15-ны өдрөөс ажиллан УСУГ-ын харьяа Төв цэвэрлэх байгууламж, Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын балансад бүртгэлтэй шинээр бий болсон 3 авто замыг газар дээр нь очиж танилцан шалгалт хийсэн.

БЗД-ийн Амгалан цогцолбор сургууль, 142-р сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийн сонгон шалгаруулалт болон Өргөө амаржих газар, БГД-ийн ЭМН-ийн хүүхдийн эмнэлгийн цайны газрын түрээслэгч сонгон шалгаруулах ажлын хэсэгт орж хяналт тавин ажилласан бөгөөд ямар нэгэн зөрчил маргаан гараагүй байна.

Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, нийслэлийн өмчит байгууллагуудын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо төрөл нормативт хяналт тавих замаар төсвийн зардлыг бууруулах арга хэмжээ авах ажлын хүрээнд нийслэлийн 301 байгууллагын 163,296.1 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 2231 тээврийн хэрэгслийн нарийвчилсан судалгааг гаргаж автомашины тоо төрөл, үнэлгээ, автомашинтай холбоотой гарсан зардлын судалгааг хийж тээврийн хэрэгсэлд бүртгэлээр хяналт тавьж ажилласан.

Нийслэлийн хэмжээнд дутагдуулсан болон маргаантай байгаа барилга байгууламжийн судалгааг гаргасан. Үүнд:

- Нийслэлийн өмчит 28 хуулийн этгээдийн балансад бүртгэлтэй 167 нэр төрлийн 11,230.0 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан. Дутагдсан хөрөнгийг нэр төрлийн хувьд авч үзвэл 1,8 хувь нь барилга, 0,1 хувь нь шугам сүлжээ, 98,1 хувь нь нийтийн эзэмшлийн эд хөрөнгө
- Маргаантай хөрөнгийн нэгтгэлд 17 хуулийн этгээдийн балансад бүртгэлтэй 74 нэрийн 1 212,9 сая төгрөгийн дахин үнэлгээ хийгдээгүй хөрөнгө байна.

БЗД-ийн 4-р хороонд байрлах “Бүтэн өнчин хүүхдүүдийн хөгжил сан”-ын барилгыг 2019.05.13-ны өдөр газар дээр нь очиж шалгахад, уг барилгад үйл ажиллагаа явуулаагүй цоожтой байгаа бөгөөд ТББ-ын тэргүүн Батдоржтой цаашид авах арга хэмжээний талаар уулзаж ярилцахыг мэдэгдсэн.

СБД-ийн Сувиллын эмнэлгийн түрээслэгч гэрээгээ цуцлуулах хүсэлт ирүүлсний дагуу тус эмнэлгийн цайны газрын талбайн хэмжилтийг хийж дараагийн сонгон шалгаруулалтын зарыг байгууллагын цахим хуудас, СБД-ийн ЭМТ-ийн цахим хуудсанд байршуулсан.

БГД-ийн 8-р хороонд байрлах “Аминжаргалан” ӨЭМТ-ийн ашиглалтгүй байгаа байрыг дараагийн үйл ажиллагаанд ашиглах талаар удирдлагад танилцуусан.

Нийслэлийн ахмадын хороо ашиглаж буй ЧД-ийн 5-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 6-р байрын 1-р давхрын 23 м² талбайтай 1 өрөөг 2019 оны 06 дугаар сарын 03-ын өдөр чөлөөлөн, дараагийн түрээслэгчтэй шууд түрээсийн гэрээг байгуулсан.

Нийслэлийн өмчит байгууллагуудад НӨАУГ-ын 2019.06.04-ний өдрийн 4/669 тоот албан бичгээр барилгын төлөв, чанар байдлын судалгаа авах тухай мэдэгдэн, дүүргүүдээс судалгааг авч нэгтгэсэн.

Нийслэлийн өмчид бүртгэлтэй 3187 барилга байгууламжийн техникийн баримт бичгийг бүрдүүлэн, улсын бүртгэлд бүртгүүлсэн эсэх, барилгын хувийн хэрэг хөтөлж, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаж зориулалтын дагуу ашиглаж буй зэрэгт хяналт тавих ажлыг эхлүүлээд байна.

5.6. Байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн талаар

Монгол Улсын Засгийн газрын 2019.04.17-ны өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны “Улсын үзлэг зохион байгуулах Төв комиссын бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай” 46 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2019.05.30-ны өдрийн А/518 захирамж “Нийслэлийн хэмжээнд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион байгууллахаар шийдвэрлэсэн.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын 2019.07.18-ны А/259 тушаалаар “Улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг” байгуулагдан Байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөнд дөрвөн шалгуур үзүүлэлтийн дагуу 98 ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР


Улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг 2019.07.23, 2019.07.26, 2019.08.01, 2019.09.26-ны өдрүүдэд тус тус 4 удаа хуралдан бэлтгэл ажлыг хангасан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбоотойгоор 2019.09.09-12-ны өдрүүдэд урьдчилсан шалгалт хийсэн.

Төв комиссын бүрэлдэхүүн 2019.10.09,10,11-ний өдрүүдэд ирж байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг шалгасны дагуу Архивын Ерөнхий газрын Улсын байцаагчийн 97/11 дугаар дүгнэлт, зөвлөмжийг танилуулсан.

Ажил шалгах 4 шалгуур үзүүлэлт тус бүрээр шалган, 94% буюу “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт 92 хувь буюу “А” үнэлгээ
2. Байгууллагын архивын үйл ажиллагаа 95 хувь буюу “А” үнэлгээ
3. Албан хэрэг хөтлөлт 93,8 хувь буюу “А”
4. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, цахим сан бүрдүүлж буй байдал 95,5 хувь буюу “А” үнэлгээ



Нийслэлийн Архивын газраас 2019.12.27-ны өдөр зохион байгуулсан улсын үзлэгт амжилттай оролцсон байгууллагуудад батламж олгох баярын хуралд оролцон “А” үнэлгээ авсан батламжаа хүлээн авсан.

5.7. Нийслэлийн Засаг даргын “Эрүүл ажлын байр удирдамж”-ийн дагуу хийсэн ажлын талаар

НӨАУГ-ын 2019.08.22-ны өдрийн А/303 дугаар тушаалаар эрүүл ажлын байр аяныг эрчимжүүлэх, зохион байгуулах “Ажлын хэсэг”-ийг Орлогч дарга Т.Төмөрбаатараар ахлуулан, зургаан хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, ажлуудаа шат дараалалтай хийж, гүйцэтгэн хамт олноо бүрэн хамруулан, идэвхи, санаачлагыг өрнүүлэн, үр өгөөжөө өгсөн, үр дүнтэй ажлуудыг зохион байгууллаа. Ажлын байранд “Ногоон орчин” бий болгох, “Эрүүл ажлын байр”-ыг сурталчлах постер, байршуулах, аян зохион байгуулах зэргээр дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:



- ✓ “Эрүүл албан хаагч” арга хэмжээ
- ✓ “Эрүүл зөв хооллолт” арга хэмжээ
- ✓ “Эрүүл ажлын байр” арга хэмжээ
- ✓ “Эрүүл өрх – Эрүүл иргэн” арга хэмжээ

Тус аяны хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах “Ажлын хэсэг” хийж хэрэгжүүлсэн ажлуудаа дүгнэн, байгууллагын удирдлагуудад танилцуулан, уралдаан,

тэмцээнүүдэд идэвхи, санаачлагатай оролцсон ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулсан. Үүнд:

- ✓ Тамхинаас гарсан 2 албан хаагч
- ✓ Нэг сарын хугацаанд хамгийн их жин хассан 2 албан хаагч
- ✓ “Эрүүл өрх – Эрүүл иргэн” өдөрлөгт идэвхтэй оролцсон 1 өрх
- ✓ Байгууллагын сагсан бөмбөгийн тэмцээний тэргүүн байр эзэлсэн хамт олон



“Эрүүл ажлын байр” удирдамжийн дагуу нийслэл хот байгуулагдсны 380 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж буй тус аяныг манай хамт олон дэмжин эерэгээр хүлээн авч, удирдамжийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг шат дараалалтай зохион байгуулж, “Эрүүл ажлын байр”-ыг бүрдүүлсэн шилдэг байгууллагаар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.

Цаашид авах арга хэмжээ:

1. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоол, НЗД-ын 2019 оны А/241 дүгээр захирамжаар Нийслэлийн өмчийн харилцааны газрын нэр, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй уялдуулан өмчийн харилцаатай холбоотой журамд өөртлөлт оруулах, шинэчлэх талаар санал боловсруулан танилцуулах,
2. Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын эдийн засгийн зорилтот түвшинг 2019 оны зорилтод түвшнөөс нэмэгдүүлэх, өр авлагыг бууруулах шинээр менежментийн өөрчлөлт хийх саналыг үйлдвэрийн газар тус бүр дээр гаргаж танилцуулах,
3. Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай”, “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” захирамжуудаар тус газарт үүрэг болгосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшил, ашиглалтад хяналт тавьж ажиллах заалтын хэрэгжилттэй холбоотой асуудлаар НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэст албан хүсэлт хүргүүлэх,
4. Шүүхийн шатанд шийдвэрлэгдээгүй удсан өмчийн харилцаатай холбоотой маргааны шалтгаан нөхцлийн талаар нарийвчлан судлаж, хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн боломжит богино хугацаанд шийдвэрлүүлэх.
5. Албан бичгийн шийдвэрлэлтийн хувийг 2018 онтой харьцуулахад 2 хувь буурсан шалтгаан нөхцлийг тодорхойлж цаашид шийвэрлэлтэд тавих хяналтыг боловсронгуй болгох замаар албан бичгийн шийдвэрлэлтийг 2020 онд 5 хувиар нэмэгдүүлэх.

/НӨАУГ-ын орлогч дарга/

/НӨАУГ-ын орлогч дарга/

/ЗСХ-ын мэргэжилтэн/

Танилцсан:

Хянасан:

Нэгтгэсэн:

Д.Төмөрбаатар

Д.Рэнцэнбямба

Б.Ууганцэцэг